



Долоо хоног тутмын хэвлэл
2016 оны 09 дүгээр сарын 27
№ 36 /945/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
хууль

1899

Монгол Улсын
хууль

1914

Монгол Улсын
хууль

1928

Монгол Улсын батлан
хамгаалах тухай
/Шинэчилсэн найруулга/

Зэвсэгт хүчний тухай
/Шинэчилсэн найруулга/

Цэргийн албаны
тухай

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

650.	Монгол Улсын батлан хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/	1899
651.	Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1910
652.	Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1910
653.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1911
654.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	1911
655.	Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1912
656.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1912
657.	Иргэний хуульд өөрчлөлт оруулах тухай	1912
658.	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1913
659.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1913
660.	Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1913
661.	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1914
662.	Зэвсэгт хүчний тухай /Шинэчилсэн найруулга/	1914
663.	Зэвсэгт хүчний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	1926
664.	Геодези, зураг зүйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1926
665.	Улсын нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1926
666.	Онц байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1927
667.	Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	1927



668.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай		1928
669.	Цэргийн албаны тухай		1928
670.	Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрхзүйн байдлын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай		1946
671.	Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1947
672.	Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1947
673.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1947
674.	Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1948
675.	Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай		1948
676.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1949
677.	Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай		1949
678.	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1956
679.	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1956
680.	Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1957
681.	Шүүхийн шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1957
682.	Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай		1958
683.	Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		1958
684.	Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай		1959
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ			
685.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 35	1959
686.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 36	1959

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоо, үйл ажиллагааг тодорхойлж, төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Батлан хамгаалах тухай хууль тогтоомж

2.1.Батлан хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“батлан хамгаалах” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалахад улсын бэлэн байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, мэдээллийн болон цэргийн нэгдмэл арга хэмжээг;

3.1.2.“батлан хамгаалах чадавх” гэж улсын эдийн засаг, хүн амын эрүүл мэнд, боловсрол, төрийн цэргийн байгуулал, мэдээллийн болон улс төр-дипломатын чадавхын нэгдлийг;

3.1.3.“батлан хамгаалах тогтолцоо” гэж батлан хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын цогцыг;

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дүгээрт нийтлэгдсэн.



3.1.4.“батлан хамгаалах бодлого” гэж улсыг батлан хамгаалах талаар төрөөс тодорхойлох зорилго, зорилтыг;

3.1.5.“батлан хамгаалах эрх ашиг” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй байдал хангагдсан байхыг;

3.1.6.“орон нутгийн хамгаалалт” гэж батлан хамгаалах үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн орон нутгийн эдийн засаг, нийгмийн тогтвортой, бие даасан хөгжлийг дэмжих, учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаас хэрэгжүүлэх олон талт арга хэмжээний цогцыг;

3.1.7.“төрийн цэргийн байгуулалт” гэж төрийн цэргийн байгууллагуудын тогтолцоог;

3.1.8.“цэргийн байгууллага” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, ард иргэдийн аюулгүй байдлыг цэргийн хүчээр хангах чиг үүрэгтэй, эрх зүйн нийтлэг хэм хэмжээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж цэргийн цол, дүрэмт хувцас хэрэглэдэг төрийн байгууллагыг;

3.1.9.“батлан хамгаалах материаллаг нөөц” гэж цэргийн материал хэрэгслийн хэрэгцээг тайван цагт болон дайны байдлын үед хангах зорилго бүхий нөөцийг.

4 дүгээр зүйл.Батлан хамгаалах үйл ажиллагааны зарчим

4.1.Батлан хамгаалах үйл ажиллагаанд дараахь зарчмыг баримтална:

4.1.1.үндэсний язгуур ашиг сонирхлыг эрхэмлэх;

4.1.2.хууль дээдлэх;

4.1.3.нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх;

4.1.4.орон нутгийн хамгаалалтад тулгуурласан байх;

4.1.5.зэвсэгт хүчин нь мэргэжлийн цэрэгт суурилсан байх;

4.1.6.нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны

тогтолцоонд тулгуурлах;

4.1.7.нэгдмэл, харилцан уялдуулан зохицуулагдсан байх;

4.1.8.шинжлэх ухаан, технологийн ололтод тулгуурлах;

4.1.9.төрийн байгууллага, иргэн харилцан хариуцлага хүлээх;

4.1.10.үндэсний эв нэгдлийг эрхэмлэх;

4.1.11.нээлттэй байх.



5 дугаар зүйл.Батлан хамгаалах үйл ажиллагаа

5.1.Батлан хамгаалах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг мөн.

5.2.Батлан хамгаалах үйл ажиллагааны зорилго нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах, иргэний аюулгүй байдлыг хангахад оршино.

5.3.Батлан хамгаалах чадавх нь улсын эдийн засаг, хүн амын эрүүл мэнд, боловсрол, төрийн цэргийн байгууллын чадавх, мэдээллийн болон улс төр-дипломатын хүч нөөцөөр хангагдана.

5.4.Улсыг батлан хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ нь нэгдмэл байна.

5.5.Хүн амыг гамшиг, гэнэтийн бусад аюул, аливаа хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хамгаалах нь батлан хамгаалах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд нэгдсэн төлөвлөлт, нэгдмэл тогтолцоотой байна.

5.6.Дайн бүхий байдал, дайны байдал зарласан үед батлан хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

6 дугаар зүйл.Улсыг батлан хамгаалах төрийн үүрэг

6.1.Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалах нь төрийн үүрэг мөн. Төр нь улсыг батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлнэ.

6.2.Монгол Улс гадны зэвсэгт халдлага, түрэмгийллийг өөрийн зэвсэгт хүчнээр няцааж, ард түмний оролцоотойгоор хамгаалах бөгөөд шаардлагатай тохиолдолд олон улсын байгууллага, бусад улсын тусламжийг авч болно.

7 дугаар зүйл.Батлан хамгаалах тогтолцоо

7.1.Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллага, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа байна.

7.2.Монгол Улс орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлнэ.

7.3.Орон нутгийн хамгаалалт нь Монгол Улсын өөрийгөө хамгаалах стратеги бөгөөд төрийн бүх шатны байгууллагын хамтын ажиллагаа, бүх нийтийн оролцоонд тулгуурлана.



7.4.Орон нутгийн хамгаалалтын харилцааг хуулиар зохицуулна.

7.5.Зэвсэгт хүчин нь үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах чиг үүрэг бүхий цэргийн байгууллагын тогтолцоо мөн бөгөөд Монгол Улс мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг зэвсэгт хүчнийг бүрдүүлж, бэхжүүлнэ.

7.6.Монгол Улс нэгдсэн удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны тогтолцоог бүрдүүлнэ.

7.7.Дайчилгааны бэлтгэлийг хангах, дайчилгаа явуулах харилцааг хуулиар зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛАЛ

8 дугаар зүйл.Монгол Улсын төрийн цэргийн байгуулал

8.1.Монгол Улсын төрийн цэргийн байгууллын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ.

8.2.Төрийн цэргийн байгууллагууд нь цэргийн эрх зүйн хэм хэмжээ, цэргийн нийтлэг дүрмүүд, цэргийн цол, цэргийн алба хаагчийн бие бялдрын стандарт, энхийг дэмжих ажиллагаанд оролцох байдлаараа нэгдмэл байна.

8.3.Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын бүтэц, эрх, чиг үүргийг хуулиар зохицуулна.

8.4.Төрийн цэргийн байгууллыг Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон төр, нийгмийн байгууллын үндэс, иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа хэлбэрээр ашиглахыг хориглоно.

9 дүгээр зүйл.Монгол Улсын төрийн цэргийн байгууллын удирдлага

9.1.Монгол Улсын төрийн цэргийн байгууллын удирдлага нь улс төрийн дээд, төрийн захиргааны, цэргийн мэргэжлийн дээд удирдлагаас бүрдэх бөгөөд эдгээр удирдлагыг дараахь байгууллага, албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд хэрэгжүүлнэ:

9.1.1.төрийн цэргийн байгууллын улс төрийн дээд удирдлагыг Монгол Улсын Их Хурал;

9.1.2.төрийн цэргийн байгууллын төрийн захиргааны удирдлагыг Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Монгол Улсын Засгийн газар, батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн;



9.1.3.төрийн цэргийн байгууллын цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг Зэвсэгт хүчний Жанжин штаб.

9.2.Цэргийн мэргэжлийн дээд удирдлага гэж цэргийн нийтлэг дүрмийн хэрэгжилт болон зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага хоорондын нэгдсэн ажиллагааг төлөвлөх, бэлэн байдлыг хангах хамтарсан сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөлтийг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, цэргийн байгууллагын зэвсэглэл, техникийн харилцан уялдааг хангах, холбоо мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн удирдлагын цогц үйл ажиллагааг ойлгоно.

9.3.Төрийн цэргийн байгууллын цэргийн мэргэжлийн удирдлагыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хилийн ба дотоодын цэргийн командлагч, онцгой байдлын байгууллагын дарга болон төрлийн цэргийн командлагч хамтран хэрэгжүүлэх бөгөөд түүний уялдаа холбоог хангах ажлыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга хариуцна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ БАТЛАН ХАМГААЛАХЫН УДИРДЛАГЫН БҮРЭН ЭРХ

10 дугаар зүйл.Батлан хамгаалахын удирдлага

10.1.Батлан хамгаалахын удирдлагыг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Монгол Улсын Засгийн газар, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ.

11 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

11.1.Батлан хамгаалах талаар Монгол Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.батлан хамгаалах бодлого, тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох;

11.1.2.дайны аюулыг сэрэмжлэх, маргаантай асуудлыг бусад улстай олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчмыг баримтлан улс төр-дипломатын аргаар шийдвэрлэх;

11.1.3.цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохируулж тогтоох;

11.1.4.гадаадын цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх эрх зүйн үндсийг тогтоох;

11.1.5.улсыг батлан хамгаалах үйл ажиллагааны төсвийг батлах;

11.1.6.батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох;



11.1.7. батлан хамгаалах үйл ажиллагааны төсвийн санхүүжилт, зарцуулалт, батлан хамгаалахын нөөцийн бүрдүүлэлт, хадгалалтын талаархи мэдээллийг жил тутам сонсох;

11.1.8. батлан хамгаалах хэрэгцээнд зориулан газрын зөвшөөрөл олгох, цуцлах.

12 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх

12.1. Монгол Улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээс гадна дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1. батлан хамгаалах бодлогын үндсийг Засгийн газартай зөвшилцөн тодорхойлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

12.1.2. батлан хамгаалахад зайлшгүй шаардагдах нөөцийг бүрдүүлэх, зэвсэг, техникийг шинэчлэх төсвийг шийдвэрлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх;

12.1.3. батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний мэдээллийг сонсож, түүний дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газарт чиглэл өгөх;

12.1.4. цэргийн нийтлэг дүрмүүдийг батлах;

12.1.5. дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтоох;

12.1.6. бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгааг хууль тогтоомжид заасны дагуу зарлах.

13 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

13.1. Монгол Улсын Засгийн газар нь Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн² 13 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1. улсыг батлан хамгаалах болон орон нутгийн хамгаалалтын асуудлаар төрийн захиргааны байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагааг удирдах;

13.1.2. цэргийн анги, байгууллагыг байгуулах, өргөтгөн зохион байгуулах, шилжүүлэх, татан буулгах асуудлыг Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн шийдвэрлэх;

13.1.3. цэргийн анги, байгууллагын байршлыг тогтоох;

² Монгол Улсын Засгийн газрын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1993 оны 03 дугаарт нийтлэгдсэн.

13.1.4.төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврыг тогтоох;

13.1.5.батлан хамгаалах материаллаг нөөцийн хэмжээ, байршлыг тогтоох, түүнийг бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг зохион байгуулах;

13.1.6.иргэнийг эх орноо батлан хамгаалахад сургаж бэлтгэх, эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд төрийн бүх шатны болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх;

13.1.7.бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд, залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил болон аюулгүй амьдрах арга ухаан олгох хичээлийн агуулгыг тусгаж, хэрэгжүүлэх;

13.1.8.цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгож, иргэний цэргийн алба хаах хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн урамшуулалт бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

13.1.9.иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журмыг тогтоох;

13.1.10.зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байх;

13.1.11.цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг үйлдвэрлэх, экспортлох, импортлох, хангах, хадгалах журмыг тогтоох;

13.1.12.батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны Монгол Улсын олон улсын гэрээний хүрээнд бүрэн эрхийнхээ дагуу олон улсын байгууллага болон бусад улсын Засгийн газартай олон улсын гэрээ байгуулах;

13.1.13.цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, шинжлэх ухаан технологийн ололтыг цэргийн хэрэгт нэвтрүүлэх;

13.1.14.аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах бүрэлдэхүүнтэй сургалт, дадлага явуулах журмыг тогтоох.

14 дүгээр зүйл.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

14.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:



14.1.1. батлан хамгаалах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

14.1.2. батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлэх саналыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах;

14.1.3. батлан хамгаалах асуудлаар бусад улстай хамтран ажиллах талаар Засгийн газраас олгосон эрхийн хүрээнд хэлэлцээр байгуулах;

14.1.4. батлан хамгаалах болон зэвсэгт хүчний хангалт, үйлчилгээний зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг батлах;

14.1.5. улсын эдийн засаг, нийгэм, дэд бүтцийг хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааг батлан хамгаалах эрх ашигт нийцүүлэх тухай саналыг Засгийн газарт оруулж, шийдвэрлүүлэх;

14.1.6. улсын хэмжээнд цэргийн спортын бодлогыг хэрэгжүүлж, хяналт тавих;

14.1.7. батлан хамгаалах аж үйлдвэрийг хөгжүүлэх, зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

14.1.8. аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх асуудлаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага төрийн цэргийн байгууллагад үүрэг, чиглэл өгөх, хэрэгжилтэд хяналт тавих;

14.1.9. аливаа хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хамгаалах талаар баримтлах бодлогын үндсийг тодорхойлох, үйл ажиллагааг нь улсын хэмжээнд удирдан чиглүүлэх;

14.1.10. батлан хамгаалах салбарын материал техникийн, санхүүгийн болон бусад нөөцийг хуулийн дагуу бүрдүүлэх, зарцуулалтад хяналт тавих;

14.1.11. зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэх;

14.1.12. батлан хамгаалах үйл ажиллагааны төсвийн төслийг Засгийн газарт оруулах, батлагдсан төсвийг захиран зарцуулах;

14.1.13. батлан хамгаалахын төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах, устгах, шилжүүлэх, шинээр авах асуудлыг шийдвэрлэх, захиалгыг хянаж батлах;

14.1.14. батлан хамгаалах үйл ажиллагааны нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээг тогтоох;

14.1.15. батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч, улсын байцаагчийг томилох, чөлөөлөх.



15 дугаар зүйл.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний чиг үүрэг

15.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь батлан хамгаалах бодлогыг боловсруулж, түүний улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн чиглэлийн хэрэгжилтийг уялдуулан зохицуулах, зэвсэгт хүчинд иргэний хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

15.2.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд харьяа агентлаг, аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэргийн штаб, батлан хамгаалах чиглэлийн улсын үйлдвэрийн газар, цэргийн сургууль, судалгаа шинжилгээ, сургалт-үйлдвэрлэл, туршилт, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн байгууллагатай байна.

15.3.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

15.3.1.батлан хамгаалах бодлого, стратегийг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

15.3.2.улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах;

15.3.3.зэвсэгт хүчнийг зэвсэглэл, техник, материал хэрэгслээр нөхөн хангах, шинэчлэх, нөөцийг бүрдүүлэх бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

15.3.4.батлан хамгаалахын хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх, цэргийн алба хаагч, түүний гэр бүл, бэлтгэл болон чөлөөнд байгаа офицер, ахлагчийн нийгмийн хамгаалал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

15.3.5.цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацийн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

15.3.6.батлан хамгаалах дэд бүтцийг хөгжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

15.3.7.зэвсэгт хүчний нэгдсэн төлөвлөлтийг удирдамжаар хангах;

15.3.8.цэргийн гэрээт алба хаах мэргэжил, тооны дээд хязгаарыг жил бүр тогтоох;

15.3.9.орон нутгийн хамгаалалт, дайчилгааны арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхэд төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг даргыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

15.3.10.иргэний батлан хамгаалах талаархи бэлтгэлжилтийг хангах арга хэмжээг зохион байгуулах, батлан хамгаалахад туслах олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

15.3.11.иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх;

15.3.12.батлан хамгаалах арга хэмжээний төлөвлөлтөд шаардагдах мэдээ, судалгааны нэр төрлийг тогтоож, шаардлагатай мэдээ,



мэдээлэл, судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс гаргуулан авах;

15.3.13.иргэний эрүүл мэндийг хамгаалах, иргэнд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх талаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;

15.3.14.цэргийн зориулалттай зэвсэг, сум, галт хэрэглэл үйлдвэрлэх бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах.

15.4.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга нь цэргийн дээд цолтой байна.

16 дугаар зүйл.Төрийн байгууллагын үүрэг

16.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бусад төрийн байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

16.1.1.батлан хамгаалах бодлогын улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүйн чиглэлийн арга хэмжээг үндсэн чиг үүргийнхээ хүрээнд зохион байгуулж, хэрэгжүүлэх;

16.1.2.батлан хамгаалах арга хэмжээг эрхлэх асуудлын хүрээний байгууллагад зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

16.1.3.улсын дайчилгааны бэлтгэлийг хангах, сургалтыг зохион байгуулах;

16.1.4.улсын дайчилгааны даалгаврыг биелүүлэх;

16.1.5.батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтарсан судалгаа хийх, шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгааг гаргаж өгөх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, ИРГЭНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

17 дугаар зүйл.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг даргын үүрэг

17.1.Батлан хамгаалах талаар бүх шатны Засаг дарга дараахь үүрэг хүлээнэ:

17.1.1.батлан хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

17.1.2.орон нутгийн хамгаалалтыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэх;

17.1.3.нутаг дэвсгэрийнхээ дэд бүтцийг орон нутгийн хамгаалалтын зорилготой уялдуулан хөгжүүлэх;



17.1.4.цэргийн бүртгэлийг хөтлөх, цэрэг татах, цэргийн албанд гэрээгээр элсүүлэх, дүйцүүлэн хаалгах ажлыг зохион байгуулах;

17.1.5.дайчилгааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх бодит нөхцөлийг бүрдүүлэх;

17.1.6.дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах;

17.1.7.тайван ба дайны үед хүн амын зайлшгүй хэрэгцээнд шаардагдах гол нэр төрлийн материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах;

17.1.8.нутаг дэвсгэртээ байрлаж байгаа цэргийн анги, байгууллага, бие бүрэлдэхүүний албан үүргээ гүйцэтгэх нөхцөлийг хангах талаар хамтран ажиллах, батлан хамгаалах үйл ажиллагаатай холбогдуулан байгаль орчныг хамгаалах талаар хууль тогтоомжийн дагуу хяналт тавих;

17.1.9.батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгааг гаргаж өгөх;

17.1.10.иргэнд эх оронч үзэл, хүмүүжил, үндэсний бахархал, уламжлалыг төлөвшүүлэх, боловсрол, оюун санаа, бие бялдрыг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах;

17.1.11.батлан хамгаалахад туслах олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх;

17.1.12.цэргийн насны иргэнийг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулах.

18 дугаар зүйл.Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

18.1.Батлан хамгаалах талаар аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

18.1.1.ажилтныхаа иргэний цэргийн алба хаах үүргийг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлж, цэргийн үүрэгтнийг дайчилгааны сургууль, цугларалтад оролцуулах;

18.1.2.дайчилгааны даалгаврыг биелүүлж, үйл ажиллагаагаа дайны байдалд шилжүүлэх бэлтгэлийг хангах;

18.1.3.батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгааг гаргаж өгөх.

19 дүгээр зүйл.Иргэний үүрэг

19.1.Монгол Улсын иргэн дараахь үүрэг хүлээнэ:

19.1.1.эх орноо хамгаалах бэлтгэлтэй байх;

19.1.2.хуулиар тогтоосон иргэний цэргийн алба хаах үүргээ биелүүлэх.



**ТАВДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

20 дугаар зүйл.Батлан хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт

20.1.Батлан хамгаалах үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

21 дүгээр зүйл.Батлан хамгаалах тухай хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

21.1.Батлан хамгаалах хууль тогтоомжийг зөрчигчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ
ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.1993 оны 10 дугаар сарын 12-ны өдөр баталсан Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

**ДАЙЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Дайчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын “дайчилгааны улсын нэгдсэн төлөвлөгөө” гэснийг “улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Дайчилгааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



3 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Төрийн цэргийн бодлогын үндэс” гэснийг “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.19 дэх хэсэг нэмсүгэй:

“15.19.Батлан хамгаалах чиглэлээр:

15.19.1.цэргийн зориулалттай зэвсэглэл, техник, галт хэрэглэлийг экспортлох, импортлох;”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дипломат албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25¹ дүгээр зүйлийн 25¹.2.8 дахь заалтын “цэргийн албан хаагч” гэснийг “цэргийн алба хаагч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсэг, 523 дугаар зүйлийн 523.2.1 дэх заалтын “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.8 дахь заалтын “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.5 дахь заалтын “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтын “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж өөрчилсүгэй.



2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ
(Шинэчилсэн найруулга)**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын зэвсэгт хүчний байгуулалтын үндэс, зарчим, зэвсэгт хүчний чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, удирдлагын бүрэн эрхийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Зэвсэгт хүчний тухай хууль тогтоомж

2.1.Зэвсэгт хүчний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дүгээрт нийтлэгдсэн.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“зэвсэгт хүчний байгуулалт” гэж зэвсэгт хүчнийг байгуулах, бэхжүүлэх, бэлтгэхэд чиглэсэн төрийн бодлогоор тодорхойлогдох харилцан уялдаа бүхий арга хэмжээний цогцыг;

3.1.2.“Төрийн цэргийн номлол” гэж тайван цагт болон дайны үед зэвсэгт хүчнийг ашиглах үзэл баримтлал, арга замыг тодорхойлсон баримт бичгийг;

3.1.3.“цэргийн захиргааны удирдлага” гэж цэргийн бэлэн байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг төлөвлөх, мэргэжил арга зүйн удирдамжаар хангах, хэрэгжүүлэх, хянах, зохицуулах үйл ажиллагааг;

3.1.4.“зэвсэгт хүчний төрийн захиргааны удирдлага” гэж зэвсэгт хүчинд холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэх, бүрэн эрхийнхээ хүрээнд эрх зүйн хэм хэмжээг тогтоох, хэрэгжилтийг хангах, зэвсэгт хүчинд иргэний хяналт тавих үйл ажиллагааг;

3.1.5.“цэргийн мэргэжлийн удирдлага” гэж зэвсэгт хүчний стратегийн бодлого, төлөвлөлтийг боловсруулахад оролцож, цэргийн бодлогыг тодорхойлох, командлагч, захирагчид дэмжлэг үзүүлэх, төрөл мэргэжлийн цэргийн анги, байгууллага, салбарыг удирдлагаар хангах үйл ажиллагааг;

3.1.6.“иргэний хяналт” гэж хууль тогтоомжийн биелэлт, цэргийн удирдлагын үйл ажиллагаа, төсвийн санхүүжилт, зарцуулалтыг нээлттэй, ил тод хянах үйл ажиллагааг;

3.1.7.“төрлийн цэрэг” гэж энэ хуулиар тогтоосон чиг үүргийг хуурай газар болон агаарын зайд бие дааж, эсхүл хамтран үүрэг гүйцэтгэх зориулалт бүхий зэвсэгт хүчний бүрэлдэхүүн хэсгийг;

3.1.8.“хуурай замын цэрэг” гэж нутаг дэвсгэрийн халдашгүй дархан байдал, иргэний аюулгүй байдлыг гадны зэвсэгт халдлага түрэмгийллээс хамгаалах цэргийн хүчнийг;

3.1.9.“агаарын цэрэг” гэж улсын агаарын хил, агаарын зайн халдашгүй дархан байдалд хяналт тавих, хамгаалах цэргийн хүчнийг;

3.1.10.“цэргийн ажиллагаа” гэж зэвсэгт хүчний төрлийн цэргийн хүч, хэрэгслийг зохион байгуулалттайгаар хэрэглэхийг;

3.1.11.“цэргийн нийтлэг дүрэм” гэж цэргийн өдөр тутмын үйл ажиллагаа, албан тушаалтны эрх, үүрэг, хариуцлага, тэдгээрийн



хоорондын харилцааны хэм хэмжээг зохицуулсан эрх зүйн баримт бичгийг;

3.1.12.“зэвсэглэл” гэж цэрэг, техник, зэвсэг, цэргийн зориулалт бүхий байгууламжид шууд хөнөөл үзүүлэх, өөрийн цэрэг, техник, байгууламжийг хөнөөлийн хэрэгслээс хамгаалах зориулалт бүхий зэвсэг, техникийн цогцыг;

3.1.13.“цэргийн техник” гэж цэргийн ажиллагааны бүх төрлийн хангалтыг зохион байгуулах, цэргийг сургах зориулалт бүхий зэвсэгт тэмцлийн техник, тоног төхөөрөмжийг;

3.1.14.“цэргийн нөөц” гэж зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарыг үүрэг гүйцэтгэх үед зарцуулах зориулалт бүхий хүн нэг бүр, зэвсэглэл, цэргийн техник, нэгтгэл, анги, салбарт тогтоосон бүх төрлийн нөөцийг;

3.1.15.“цэргийн байрлал” гэж тайван цагт цэргийн нэгтгэл, анги, байгууллага, цэргийн сургуулийн талбар, бүс, цэргийн болон хээрийн хотхон, суурин, бааз болгон тогтоосон нутаг дэвсгэрийг;

3.1.16.“зэвсэгт хүчний байлдааны бэлэн байдал” гэж цагийн байдлын ямар ч нөхцөлд тогтоосон хугацаанд дээд командлалаас даалгасан үүргийг мадаггүй биелүүлэх цэргийн бодит чадварыг.

4 дүгээр зүйл.Монгол Улсын зэвсэгт хүчин

4.1.Монгол Улсын зэвсэгт хүчин нь улсыг цэргийн хүч, хэрэгслээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллага мөн.

4.2.Зэвсэгт хүчний цэргийн сүр хүчний бэлгэдэл нь “Бүх Цэргийн Их Хар Сүлд” мөн бөгөөд түүнийг хадгалах, залах, цэнгүүлэх асуудлыг Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн баталсан тусгай журмаар зохицуулна.

4.3.Зэвсэгт хүчин нь Жанжин туг, төрлийн цэрэг, нэгтгэл, анги, байгууллага нь байлдааны туг, бэлгэ тэмдэгтэй байна.

4.4.Зэвсэгт хүчнийг Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон төр, нийгмийн байгууллын үндэс, иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа хэлбэрээр ашиглахыг хориглоно.

4.5.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардагдах тусгай хэрэгцээний газартай байна.

4.6.Зэвсэгт хүчний тусгай хэрэгцээний газрыг бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.

4.7.Зэвсэгт хүчний цэргийн нэгтгэл, анги, байгууллага, салбарын тусгай хэрэгцээний газрын хилийн цэсээс гадагш тодорхой зайд хориотой бүс тогтооно.

4.8.Монгол Улсын нутаг дэвсгэрт цэргийн байгууллага хууль бусаар байгуулахыг хориглоно.



5 дугаар зүйл.Зэвсэгт хүчний байгуулалтын үндэс ба зарчим

5.1.Зэвсэгт хүчний байгуулалтын үндсийг төрийн бодлого, хууль тогтоомжоор тодорхойлно.

5.2.Зэвсэгт хүчний байгуулалт нь дараахь зарчимд тулгуурлана:

5.2.1.зэвсэгт хүчин нь иргэний хяналтад байх;

5.2.2.зэвсэгт хүчнийг төрөөс удирдах;

5.2.3.зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл нь түүний тайван цагт болон дайны байдлын үед гүйцэтгэх үүрэгт зохицсон байх;

5.2.4.зэвсэгт хүчин үүргээ биелүүлэхэд байнга бэлэн байх;

5.2.5.зэвсэгт хүчний бүх төрлийн хангалтыг төрөөс баталгаажуулах;

5.2.6.зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг цэрэг татлагаар болон гэрээгээр сайн дурын үндсэн дээр нөхөн хангах;

5.2.7.цэргийн алба хаагч бүр цэргийн мэргэжилд заавал сурах;

5.2.8.хууль дээдлэх, чанд сахилга, өндөр зохион байгуулалттай байх;

5.2.9.төвлөрүүлэн удирдах, нэгтгэн захирах;

5.2.10.зэвсэгт хүчин нэгдмэл байх.

6 дугаар зүйл.Зэвсэгт хүчний чиг үүрэг

6.1.Зэвсэгт хүчний үндсэн чиг үүрэг нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс өөрийгөө хамгаалах явдал мөн.

6.2.Зэвсэгт хүчин нь энэ зүйлийн 6.1-д заасан үндсэн чиг үүргээс гадна тайван цагт дараахь үүрэг хүлээнэ:

6.2.1.эх орноо гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс өөрийгөө хамгаалах бэлтгэлийг хангах;

6.2.2.агаарын хилийн халдашгүй дархан байдал, агаарын зайд хяналт тавих, хамгаалах;

6.2.3.улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх;

6.2.4.энхийг дэмжих ажиллагаанд оролцох;

6.2.5.зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх;

6.2.6.аливаа хөнөөх хэрэгслийн хөнөөлийн голомтод байгаа хүн ам, эд юмсыг аврах, хор уршгийг арилгах;

6.2.7.гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;



6.2.8.дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг сургах, хүн амыг цэргийн хэрэгт сургах, тэдэнд эх оронч үзлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

6.2.9.улсын онц чухал объектыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх;

6.2.10.цэргийн зориулалттай тэсэрч дэлбэрэх зүйлийг аюулгүй болгох.

6.3.Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр Засгийн газрын шийдвэрийн дагуу зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БИЕ БҮРЭЛДЭХҮҮН

7 дугаар зүйл.Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт

7.1.Зэвсэгт хүчин нь хуурай замын цэрэг, агаарын цэргээс бүрдэнэ.

7.2.Дайны байдал зарламагц хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллага зэвсэгт хүчний бүтцэд шилжиж, үүрэг гүйцэтгэнэ.

7.3.Зэвсэгт хүчин нь Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн командлал, төрөл, мэргэжлийн цэргийн болон барилга инженер, ар тал, техникийн нэгтгэл, ангиуд, цэргийн цагдаа, эмнэлэг, хангалт үйлчилгээний байгууллага, иргэн-цэргийн харилцааг зохицуулах нэгжтэй байна.

7.4.Цэргийн нэгтгэл, анги нь тайван цагт бүрэн, хураангуй, нэн хураангуй зохион байгуулалттай байж болно.

7.5.Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллагын тайван цагийн болон дайны үеийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цэргийн цагдаагийн ажиллах журмыг Зэвсэгт хүчний Жанжин штаб тогтооно.

8 дугаар зүйл.Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн

8.1.Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн цэргийн жинхэнэ алба хаагч, зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарт ажиллаж байгаа иргэнээс бүрдэнэ.

8.2.Цэргийн алба хаахтай холбогдсон харилцаа, цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар зохицуулна.

8.3.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарт ажиллаж байгаа иргэний эрх зүйн байдлыг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ УДИРДЛАГА

9 дүгээр зүйл.Зэвсэгт хүчний удирдлага

9.1.Зэвсэгт хүчний улс төрийн дээд удирдлагыг Монгол Улсын Их Хурал хэрэгжүүлнэ.

9.2.Зэвсэгт хүчний төрийн захиргааны удирдлагыг Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Монгол Улсын Засгийн газар, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлнэ.

9.3.Зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга хэрэгжүүлнэ.

9.4.Зэвсэгт хүчний цэргийн захиргааны удирдлагыг төрлийн цэргийн командлагч, нэгтгэл, анги, байгууллага, салбарын захирагч хэрэгжүүлнэ.

9.5.Цэргийн мэргэжлийн удирдлагыг төрөл мэргэжлийн цэргийн дарга хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

10.1.Монгол Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.зэвсэгт хүчний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох;

10.1.2.зэвсэгт хүчний хөгжлийн бодлогын хэрэгжилтийн талаар эрх бүхий албан тушаалтны мэдээлэл сонсох;

10.1.3.зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг тодорхойлох;

10.1.4.зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэхэд зориулсан жил бүрийн төсвийг батлах;

10.1.5.зэвсэгт хүчинд тайван цагт алба хаах цэргийн алба хаагчийн тооны дээд хязгаарыг Засгийн газрын саналыг үндэслэн тогтоох;

10.1.6.цэргийн тангаргийг батлах;

10.1.7.цэргийн дээд цол бий болгох;

10.1.8.улсад онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд хугацаат цэргийн алба хаах хугацааг гурван сараас дээш хугацаагаар сунгах.

11 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх

11.1.Монгол Улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.төрийн цэргийн номлолыг батлах;



11.1.2.зэвсэгт хүчнийг хэрэглэх ерөнхий болон стратегийн дэлгэн байгуулалтын төлөвлөгөөг батлах;

11.1.3.зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвчийг батлах;

11.1.4.Бүх Цэргийн Их Хар Сүлд, зэвсэгт хүчний Жанжин тугийн тодорхойлолт, дүрмийг батлах;

11.1.5.Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрмийг батлах;

11.1.6.дээд офицерын албан тушаалын ангилал, цолны зэрэглэлийг тогтоох;

11.1.7.цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварыг батлах;

11.1.8.цэргийн анги, байгууллагыг цэргийн ёслолын жагсаалын арга хэмжээнд оролцуулах журмыг тогтоох;

11.1.9.улсад онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд хугацаат цэргийн алба хаах хугацааг гурван сараас дээш хугацаагаар сунгах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

11.1.10.Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох;

11.1.11.зэвсэгт хүчний дайны үеийн бүтэц, зохион байгуулалт, зэвсэгт хүчнийг дайнд ашиглах ерөнхий төлөвлөгөөг батлах, цэргийг байлдааны бэлэн байдлын дээд зэрэгт шилжүүлэх, байлдааны ажиллагаа эхлэх шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргах;

11.1.12.улсын хил, онц чухал объектын хамгаалалтад зэвсэгт хүчнээр дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргах;

11.1.13.цэргийн алба хаагчид цэргийн цол олгох журмыг тогтоох;

11.1.14.Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын санал, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, төрлийн цэргийн командлагчийг томилох, чөлөөлөх.

12 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

12.1.Монгол Улсын Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.зэвсэгт хүчнийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг батлах;

12.1.2.зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

12.1.3.зэвсэгт хүчинд тайван цагт алба хаах цэргийн алба

хаагчийн тооны дээд хязгаарыг тогтоох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

12.1.4.зэвсэгт хүчний хэрэгцээнд худалдан авах зэвсэглэл, цэргийн техникийн төрөл, тоог тогтоож Улсын Их Хурлын зөвшөөрснөөр санхүүжүүлэх;

12.1.5.цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны асуудлаар бүрэн эрхийнхээ хүрээнд бусад улсын Засгийн газартай гэрээ байгуулах;

12.1.6.зэвсэгт хүчнийг зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүнээр хангах;

12.1.7.энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний тоо, шаардагдах зардлыг жил бүр тогтоох;

12.1.8.зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарын тусгай хэрэгцээний газрын хориотой бүс тогтоох журмыг батлах.

13 дугаар зүйл.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

13.1.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1.зэвсэгт хүчнийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

13.1.2.Монгол Улсын зэвсэгт хүчнийг байлдааны бэлэн байдлын дээд зэрэгт шилжүүлэх баримт бичгийг батлах;

13.1.3.Зэвсэгт хүчний Жанжин штабын тайван цагийн бүтэц, орон тоо, цалингийн сангийн хэмжээг тогтоох;

13.1.4.зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэн сайжруулах саналыг Засгийн газарт өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэх;

13.1.5.зэвсэгт хүчний батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавих, ангилал хооронд зохицуулалт хийх;

13.1.6.зэвсэгт хүчнийг зэвсэглэл, цэргийн техник, материал хэрэгслээр нөхөн хангах ажлыг зохион байгуулах;

13.1.7.зэвсэгт хүчинд шинээр нэвтэрч байгаа зэвсэглэл, цэргийн техникийг хүлээн авах журмыг тогтоох;

13.1.8.цэргийн нөөцийн хэмжээ, цувраажилтыг батлах;

13.1.9.улсын нөөцөд байх зэвсэгт хүчний хэрэгцээт материал хэрэгслийн төрөл, тоо, хэмжээ, байршлын талаар Засгийн газарт санал оруулах;

13.1.10.хугацаат цэргийн алба хаах иргэний тоо, цэрэг татлага явуулах ээлж, хугацааг тогтоох саналыг Засгийн газарт оруулах;

13.1.11.цэргийн нийтлэг дүрмийг батлуулахаар Монгол Улсын



зэвсэгт хүчний ерөнхий командлагчид өргөн мэдүүлэх;

13.1.12.зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэх.

13.2.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн нарийн бичгийн дарга зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

14 дүгээр зүйл.Зэвсэгт хүчний Жанжин штабын үүрэг

14.1.Зэвсэгт хүчний Жанжин штаб төрийн цэргийн байгууллын цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага мөн.

14.2.Зэвсэгт хүчний Жанжин штаб дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

14.2.1.зэвсэгт хүчнийг цэргийн мэргэжлийн нэгдмэл удирдлагаар хангах;

14.2.2.батлан хамгаалах бодлого боловсруулахад оролцож, зэвсэгт хүчинд хамаарах асуудлыг хэрэгжүүлэх;

14.2.3.төрийн цэргийн номлолыг боловсруулах;

14.2.4.зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн арга хэмжээг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах;

14.2.5.зэвсэгт хүчнийг хэрэглэх, стратегийн дэлгэн байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

14.2.6.зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх;

14.2.7.цэргийн дайчилгааны даалгаврыг боловсруулж, биелэлтийг нь хангах арга хэмжээг зохион байгуулах;

14.2.8.зэвсэгт хүчний бэлэн байдал, байлдах чадварыг хангах, байлдааны жижүүрлэлтийн горимыг тогтоох;

14.2.9.зэвсэгт хүчний нэгдсэн ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах;

14.2.10.олон улсын болон бүс нутгийн цэрэг-улс төрийн ба цэрэг-стратегийн байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Улсын Их Хурал, Засгийн газрыг мэдээллээр хангах;

14.2.11.цэргийн мэдээлэл, дүн шинжилгээ, орон зайн тандалт судалгаа явуулах;

14.2.12.цэргийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах, цэргийн урлагийг хөгжүүлэх;

14.2.13.цэргийн удирдлага, мэдээллийн хэрэгслийн шинэчлэлийн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

14.2.14.цэргийн боловсрол, сургалт бэлтгэлийн бодлогыг

тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих;

14.2.15.төрлийн цэргийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, бэхжүүлэх;

14.2.16.зэвсэгт хүчний хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах;

14.2.17.цэрэг татах, халах ажлыг зохион байгуулах;

14.2.18.зэвсэгт хүчнийг зэвсэглэл, цэргийн техник, бусад материал хэрэгслээр хангах асуудлаар санал боловсруулж, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргэх;

14.2.19.цэргийн нөөцийг бүрдүүлэх, сольж шинэчлэх ажлыг зохион байгуулах;

14.2.20.зэвсэгт хүчний хэмжээнд төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах;

14.2.21.орон нутгийн хамгаалалтын арга хэмжээнд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

14.2.22.хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хүн ам, эд баялгийг аврах, хор уршгийг арилгах бэлтгэлийг хангах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах.

14.3.Зэвсэгт хүчний Жанжин штабын бусад эрх, үүрэг, төрийн цэргийн байгууллага, төрлийн цэргийн командлалтай харилцах хэм хэмжээг Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрмээр зохицуулна.

15 дугаар зүйл.Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын бүрэн эрх

15.1.Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга цэргийн удирдлагын дээд байгууллагыг тэргүүлнэ.

15.2.Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний удирдлагад ажиллана.

15.3.Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчид цэргийн бодлогын асуудлаар зөвлөх үүрэг хүлээнэ.

15.4.Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.4.1.цэргийн мэргэжлийн дээд удирдлагын уялдаа холбоог хангах;

15.4.2.батлан хамгаалах төрийн бодлогыг боловсруулахад оролцож, хэрэгжилтийг зохион байгуулах;

15.4.3.төрийн цэргийн номлол, стратегийн төлөвлөлтийн баримт бичгийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын



гишүүнд танилцуулж, Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчид өргөн мэдүүлэх;

15.4.4.Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх журам тогтоож, биелэлтийг хянах;

15.4.5.цэргийн удирдлагын дээд байгууллагын албан тушаалтан, нэгтгэл, ангийн захирагчийг төрлийн цэргийн командлагчийн санал болгосноор томилж, чөлөөлөх;

15.4.6.цэргийн бэлтгэл албаны офицер, ахлагчийг цэргийн жинхэнэ албанд татах;

15.4.7.хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу албан тушаалын цол олгох, бууруулах, хураан авах, сахилга, ёс зүйн хариуцлага хүлээлгэх;

15.4.8.цэргийн байгууллагуудын харилцан ажиллах журам тогтоох, нэгдсэн ажиллагааны төлөвлөгөөг батлах;

15.4.9.төсөв, хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулах;

15.4.10.зэвсэгт хүчинтэй холбоотой асуудлаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд мэдээлэл хийх;

15.4.11.төрлийн цэрэг, зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын бэлгэ тэмдгийн загвар, тугийн тодорхойлолтыг батлах;

15.4.12.төрлийн цэргийн командлалын дүрмийг баталж, харилцан ажиллагааны журмыг тогтоох;

15.4.13.цэргийн албыг зохион байгуулах зааврыг батлах;

15.4.14.цэргийн алба хаагчийн албан тушаалын шалгуур үзүүлэлт болон цэргийн мэргэжлийн зэргийн үндсэн шалгуур үзүүлэлтийг тогтоох;

15.4.15.цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрмийг батлах;

15.4.16.цэргийн албаа үлгэр жишээчээр хааж, цэргийн зохих мэргэжил эзэмшсэн хугацаат цэргийн алба хаагчийг цэргийн албаны хугацаа дуусахаас гурав хүртэл сарын өмнө халах;

15.4.17.төрийн ёслолын цэргийн арга хэмжээг зохион байгуулах;

15.4.18.байлдааны дүрэм, зааврыг батлах.

15.5.Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга нь төрийн тусгай албан хаагч байна.

16 дугаар зүйл.Төрлийн цэргийн командлагчийн нийтлэг

бүрэн эрх

16.1.Төрлийн цэргийн командлагч нь тухайн цэргийн захиргааны



удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд дараахь нийтлэг бүрэн эрхтэй байна:

16.1.1.командлалын хэмжээнд хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх;

16.1.2.бие бүрэлдэхүүний сургалт, штабын бэлтгэлийг удирдан чиглүүлэх;

16.1.3.цэргийн зэвсэглэл, техникийн бэлэн байдлыг хангах;

16.1.4.цэргийн ажиллагааг удирдах;

16.1.5.зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарын бэлэн байдал, байлдах чадварыг хангах;

16.1.6.зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарын бүх төрлийн хангалтыг зохион байгуулах;

16.1.7.цэргийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих;

16.1.8.төсөв, хөрөнгийг хууль тогтоомжид заасны дагуу захиран зарцуулах.

16.2.Энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг төрлийн цэргийн командлалын дүрмээр зохицуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

БУСАД ЗҮЙЛ

17 дугаар зүйл.Улс төрийн нам, олон нийтийн болон шашны байгууллагын үйл ажиллагаа

17.1.Зэвсэгт хүчинд улс төрийн нам, улс төрийн зорилготой олон нийтийн, шашны байгууллага байгуулахыг хориглоно.

17.2.Зэвсэгт хүчинд цэргийн алба хаагч болон хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хүрээнд ажиллаж байгаа иргэн улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

18 дугаар зүйл.Зэвсэгт хүчний санхүүжилт

18.1.Зэвсэгт хүчнийг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

19 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1.Зэвсэгт хүчний тухай хууль тогтоомжийг зөрчигчид холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2002 оны 05 дугаар сарын 16-ны өдөр баталсан Зэвсэгт хүчний тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зэвсэгт хүчний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийн “Зэвсэгт хүчний ерөнхий штаб” гэснийг “Зэвсэгт хүчний Жанжин штаб” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зэвсэгт хүчний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Улсын нөөцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“3.1.3.”Батлан хамгаалах материаллаг нөөц” гэж Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 3.1.9-д заасныг;”

2 дугаар зүйл.Улсын нөөцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “цэргийн дайчилгааны” гэснийг “батлан хамгаалах материаллаг” гэж, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “цэргийн дайчилгааныхаас” гэснийг “батлан хамгаалах материаллагаас” гэж тус тус өөрчилсүгэй.



3 дугаар зүйл. Улсын нөөцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Зэвсэгт хүчний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Онц байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтын “Зэвсэгт хүчний ерөнхий штаб” гэснийг “Зэвсэгт хүчний Жанжин штаб” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зэвсэгт хүчний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зэвсэгт хүчний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25¹ дүгээр зүйлийн 25¹.2.9 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зэвсэгт хүчний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэн Монгол Улсын Үндсэн хуульд заасан үүргийнхээ дагуу эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмших, цэргийн алба хаахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Цэргийн албаны тухай хууль тогтоомж

2.1.Цэргийн албаны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“цэргийн алба” гэж зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагад Монгол Улсын иргэн цэргийн алба хаах үндсэн үүргийг биеэр гүйцэтгэх, эсхүл цэргийн бүртгэлд байхыг;

3.1.2.“цэргийн жинхэнэ алба” гэж Монгол Улсын иргэн цэргийн байгууллагад цэргийн алба хаах үүргийг биеэр гүйцэтгэхийг;

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дүгээрт нийтлэгдсэн.

3.1.3. “цэргийн дүйцүүлэх алба” гэж Монгол Улсын иргэн шашин шүтлэг, ёс зүйн болон энэ хуульд заасан бусад үндэслэлээр цэргийн албыг дүйцүүлэн хаахыг;

3.1.4. “цэргийн бэлтгэл алба” гэж энэ хуульд заасан бэлтгэл албаны насны эрэгтэйчүүд, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд цэргийн бүртгэлд байх, дайчилгааны цугларалт, сургуульд оролцохыг;

3.1.5. “цэргийн жинхэнэ алба хаагч” гэж цэргийн байгууллагад цэргийн алба биеэр хааж байгаа Монгол Улсын иргэнийг;

3.1.6. “офицерын алба” гэж Монгол Улсын иргэн цэргийн байгууллагад офицерын албан тушаалд цэргийн жинхэнэ алба хаахыг;

3.1.7. “ахлагчийн алба” гэж Монгол Улсын иргэн цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр цэргийн байгууллагад ахлагчийн албан тушаалд цэргийн жинхэнэ алба хаахыг;

3.1.8. “хугацаат цэргийн алба хаагч” гэж цэргийн албанд татагдан цэргийн байгууллагад энэ хуулиар тогтоосон хугацаанд цэргийн жинхэнэ албыг биеэр хааж байгаа иргэнийг;

3.1.9. “цэргийн гэрээт алба хаагч” гэж цэргийн байгууллагад сайн дураар гэрээгээр цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг;

3.1.10. “оюутан-цэрэг” гэж цэргийн мэргэжил олгох сургалтад сайн дураар хамрагдаж байгаа их, дээд сургуулийн эрэгтэй оюутан, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн эрэгтэй суралцагчийг;

3.1.11. “цэргийн сургуулийн сурагч” гэж цэргийн хөгжмийн болон цэргийн дунд сургуульд суралцагчийг;

3.1.12. “цэргийн бэлтгэл үүрэгтэн” гэж цэргийн бүртгэлд байгаа Монгол Улсын иргэнийг;

3.1.13. “цэргийн цол” гэж цэргийн алба хаагчийн эрхэлж байгаа албан тушаалын ангилал, цэргийн боловсрол, цэргийн жинхэнэ алба хаасан хугацааг илэрхийлсэн зэрэглэлийг;

3.1.14. “цэргийн бүртгэл” гэж цэргийн бэлтгэл үүрэгтний тоо, чанарт дүн шинжилгээ хийх бүртгэлийн тогтолцоог;

3.1.15. “цэргийн жинхэнэ албанд татагдагч” гэж цэргийн жинхэнэ албанд татах тухай зарлан дуудах мэдэгдэл авсан иргэнийг;

3.1.16. “цэрэгт бүртгэлтэй мэргэжил” гэж цэргийн алба хаагч, цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн, цэргийн бүртгэлд авах шаардлага бүхий иргэний мэргэжлийг;

3.1.17. “нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн” гэж цэргийн жинхэнэ алба хаасан байлдагч, түрүүч, ахлагч, офицерыг;

3.1.18. “хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн” гэж цэргийн бүртгэлд байгаа цэргийн алба хаагаагүй эрэгтэйчүүд болон цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг.



4 дүгээр зүйл. Иргэний цэргийн үүрэг

4.1. Монгол Улсын иргэн цэргийн албанд татагдах, элсэх, цэргийн мэргэжил эзэмших, цэргийн байгууллагад цэргийн алба хаах үүрэг гүйцэтгэх, цэргийн бэлтгэл үүрэгтэн цэргийн бүртгэлд байх, цэргийн дайчилгааны цуглралт, сургуульд оролцох нь цэргийн үүрэгт хамаарна.

4.2. Монгол Улсын иргэн нь үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр цэргийн үүрэг хүлээнэ.

4.3. Дайны байдлын үед иргэний цэргийн үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

4.4. Цэргийн бүртгэлийг Монгол Улсын нутаг дэвсгэрт жилд нэг удаа зохион байгуулах ба түүнд цэрэгт бүртгэлтэй иргэн бүр хамрагдана.

5 дугаар зүйл. Цэргийн тангараг

5.1. Монгол Улсын иргэн цэргийн жинхэнэ албанд орохдоо:

“Монгол Улсын иргэн Би Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ үнэнчээр биелүүлж, өвөг дээдсийнхээ ариун гал голомт болсон Монгол Улсынхаа халдашгүй дархан байдлыг амь бие үл хайрлан батлан хамгаалахаа эх орон, төр, ард түмэндээ андгайлан тангараглая.

Би ард түмнийхээ үндэсний эв нэгдэл, Монгол цэргийн шилдэг уламжлалаа эрхэмлэн хүндэтгэж, цэргийн эрдэмд шамдан боловсорч, улсын нууцыг найдвартай хадгалж, Монгол Улсын хууль, цэргийн дүрмийг чанд сахин биелүүлэхээ батлан тангараглая.

Эх орноо батлан хамгаалагч дайчин Би өргөсөн тангаргаасаа няцваас төрийн хууль ёсны цээрлэл хүлээнэ.” гэж цэргийн тангараг өргөнө.

5.2. Цэргийн тангараг өргөх ёслолын журмыг цэргийн дүрмээр зохицуулна.

5.3. Цэргийн тангараг өргөсөн баримт бичгийг цэргийн алба хаагчийн хувийн хэрэгт хадгална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЦЭРГИЙН АЛБА, ТҮҮНИЙ АНГИЛАЛ, ТӨРӨЛ

6 дугаар зүйл. Цэргийн алба, түүний төрөл

6.1. Цэргийн алба нь цэргийн жинхэнэ алба, цэргийн бэлтгэл албанаас бүрдэнэ.

6.2. Цэргийн жинхэнэ алба нь хугацаат болон цэргийн гэрээт алба, ахлагчийн алба, офицерын албанаас бүрдэнэ.

6.3. Цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд сайн дураар офицерын ба ахлагчийн албыг хуулийн дагуу хааж болно.

6.4.Цэрэгт бүртгэлтэй мэргэжлийн жагсаалтыг Засгийн газар батална.

6.5.Цэргийн бэлтгэл алба нь нэгдүгээр зэргийн ба хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний албанаас бүрдэнэ.

7 дугаар зүйл.Хугацаат цэргийн алба

7.1.Хугацаат цэргийн алба хаах хугацаа 12 сар байна.

7.2.Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч онцгой нөхцөл бий болсон үед хугацаат цэргийн алба хаагчийн алба хаах хугацааг гурав хүртэл сараар сунгаж болно.

7.3.Хугацаат цэргийн алба хааж эхэлсэн хугацааг цэргийн анги, салбарт хуваарилсан өдрөөс, дуусгасан хугацааг бэлтгэлээр халах тухай цэргийн ангийн захирагчийн тушаалд заасан өдрөөс тус тус тооцно.

7.4.Иргэний хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаар 27 байна.

7.5.Иргэн хугацаат цэргийн албанд татагдахаас өмнө ажил, хөдөлмөр эрхэлж байсан бол ажил олгогч нь түүнийг халагдаж ирэхэд ажлын байраар хангана.

7.6.Цэргийн сургуулийн оюутан суралцаж байх хугацаандаа цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдаж, цэргийн мэргэжил эзэмшсэн бол түүнийг хугацаат цэргийн алба хаасанд тооцож, цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ.

7.7.Цэргийн сургуулиас бусад их, дээд сургуулийн эрэгтэй оюутан, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн эрэгтэй суралцагч сайн дурын үндсэн дээр цэргийн мэргэжил олгох “Оюутан-цэрэг” сургалтад хамрагдаж болно.

7.8.Цэргийн мэргэжил эзэмшсэн оюутныг цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ.

7.9.“Оюутан-цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтын журмыг Засгийн газар батална.

8 дугаар зүйл.Цэргийн гэрээт алба

8.1.Монгол Улсын иргэн сайн дураар цэргийн албыг гэрээгээр хааж болно.

8.2.Хугацаат цэргийн алба хаасан иргэн цэргийн гэрээт албыг байлдагч, түрүүчээр хаах анхны хугацаа 24 сар байх бөгөөд гэрээний хугацааг цаашид хоёр жилээр 31 нас хүртэл сунгаж болно.

8.3.Шаардлагатай мэргэжил, албан тушаалд иргэнийг ахлагч, офицероор тав хүртэл жилийн хугацаагаар цэргийн гэрээт албанд элсүүлж болно.

8.4.Ахлагч, офицероор цэргийн гэрээт албанд элсүүлэх мэргэжил, албан тушаалын жагсаалтыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын болон цэргийн мэргэжлийн байгууллага батална.



9 дүгээр зүйл.Цэргийн сургуулийн сонсогч, сурагч

9.1.Цэргийн сургуульд суралцаж байгаа байлдагч, түрүүч, ахлагч, офицерыг сонсогч гэнэ.

9.2.Цэргийн сургуульд 17 нас хүрсэн Монгол Улсын иргэнийг элсүүлэн суралцуулж болно.

9.3.Сонсогчийн цэргийн сургуульд суралцсан хугацааг иргэний ажилласан, цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоох хугацаанд оруулан тооцно.

9.4.Цэргийн сургуулийн сонсогчид боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

9.5.Цэргийн сургуулийн сонсогч, сурагчийн ахуй хангалт, дүрэмт хувцсыг төр хариуцна.

9.6.Цэргийн хөгжмийн болон цэргийн дунд сургуулийн үлгэрчилсэн дүрэм, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, элсэлтийн журмыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.

9.7.Цэргийн сургуулийн дүрмийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10 дугаар зүйл.Ахлагчийн алба

10.1.Цэргийн зохих шатны сургууль, дамжаанд суралцаж, цэргийн мэргэжил эзэмшсэн 30 хүртэлх насны иргэнийг ахлагчийн албанд элсүүлж болно.

10.2.Ахлагчийн албан тушаал нь даргалах, гүйцэтгэх гэсэн ангилалтай байна.

10.3.Ахлагчийн алба хаагч нь боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн зохих шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

10.4.Энэ зүйлийн 10.3-т заасан шалгуур үзүүлэлтийг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага батална.

10.5.Иргэн ахлагчийн албыг 47 нас хүртэл хаана.

10.6.Алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар, дадлагатай ахлагчийн цэргийн жинхэнэ алба хаах хугацааг томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.

11 дүгээр зүйл.Офицерын алба

11.1.Офицерын алба хаагч нь боловсрол, мэргэжил, ур чадвар, эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн зохих шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

11.2.Энэ зүйлийн 11.1-д заасан шалгуур үзүүлэлтийг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага батална.

11.3.Офицерыг дунд, ахлах, дээд гэж ангилна.

11.4.Офицерын албыг дунд офицер 47 нас хүртэл, ахлах офицер 52 нас хүртэл, дээд офицер 57 нас хүртэл хаана.

11.5.Эмэгтэйчүүд офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр 47 нас хүртэл хаана.

11.6.Алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар, дадлагатай офицерын цэргийн жинхэнэ алба хаах хугацааг томилсон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тав хүртэл жилээр нэг удаа сунгаж болно.

11.7.Ажлын зайлшгүй шаардлага, мэргэжлийн онцлогийг харгалзан цэргийн сургуулийн багш, цэргийн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмчийн офицерын алба хаах хугацааг дахин сунгаж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАНД ТАТАХ, ХАЛАХ, ЧӨЛӨӨЛӨХ, НӨХӨН ХААЛГАХ

12 дугаар зүйл.Хугацаат цэргийн албанд татах

12.1.Цэргийн жинхэнэ албанд тухайн жилд татах иргэний тоо, татлага явуулах ээлж, хугацааг Засгийн газар батална.

12.2.Монгол Улсын иргэн 18-25 насны эрэгтэйчүүдийг хугацаат цэргийн албанд татна.

12.3.Хугацаат цэргийн албанд татагдах иргэнд цэргийн жинхэнэ албанд татах тухай цэргийн зарлан дуудах мэдэгдэл хүргүүлнэ.

12.4.Хугацаат цэргийн албанд татагдах иргэний цэрэг татлагын байранд ирсэн байх өдөр, цагийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар батална.

12.5.Зарлан дуудах мэдэгдэл авсан иргэн тогтоосон өдөр, цагт цэрэг татлагын байр болон товлосон газарт ирсэн байх үүрэгтэй.

12.6.Цэргийн зарлан дуудах мэдэгдэл авсан иргэн хүндээр өвчилсөн, хорио цээр тогтоогдсон, гэнэтийн аюул осол тохиолдсоноос цэрэг татлагын байранд тогтоосон хугацаанд ирж чадаагүй нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын тодорхойлолт, эмнэлгийн магадалгаагаар батлагдвал хүндэтгэн үзэх шалтгаантай байсанд тооцно.

12.7.Хугацаат цэрэг татлагын үед байнга оршин суугаа газраасаа өөр газарт түр хугацаагаар яваа иргэн тухайн нутаг дэвсгэрийн цэрэг татлагын байранд очиж бүртгүүлэх үүрэгтэй.

12.8.Байгууллагын эрх бүхий албан тушаалтан, ажил олгогч цэргийн зарлан дуудах мэдэгдэл хүлээн авсан ажилтнаа ажлаас чөлөөлөн тогтоосон хугацаанд цэрэг татлагын байранд, эсхүл товлосон газар ирүүлэх үүрэг хүлээнэ.



12.9.Цэргийн зарлан дуудах мэдэгдэл авсан иргэний аймаг, нийслэлийн цэрэг татлагын байранд хүргэхэд шаардагдах тээврийн, хүнсний ба байрны зардлыг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, цэргийн албанд тэнцсэн иргэнийг цэрэг татлагын байран дээр түр байрлуулах, хооллох, цэрэг татлагын байрнаас цэргийн анги хүргэх зардлыг хилийн ба дотоодын цэрэг, төрлийн цэргийн командлал тус тус хариуцна.

12.10.Гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэнийг цэргийн жинхэнэ албанд татах ажлыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулна.

12.11.Цэрэг татлага явуулах тухай Засгийн газрын тогтоол нийтлэгдсэн өдрөөс эхлэн цэрэг татлагын хугацаа дуусах өдөр хүртэл цэргийн албанд татагдах насны иргэн тухайн нутгийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүйгээр гадаадад зорчихыг хориглоно.

13 дугаар зүйл.Цэрэг татлагын товчоо

13.1.Цэргийн албаны ээлжит татлагыг эрхлэн явуулах цэрэг татлагын товчоог дарга, орлогч, нарийн бичгийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулах бөгөөд цэрэг татлагын товчооны бүрэлдэхүүнд төрийн захиргааны байгууллагын зохих албан тушаалтан болон шаардлагатай мэргэжлийн байгууллагын ажилтныг томилон ажиллуулна.

13.2.Цэрэг татлагын товчоо дараахь үүрэг хүлээнэ:

13.2.1.Засгийн газраас тогтоосон ээлж, хугацаанд цэрэг татлагыг зохион байгуулах;

13.2.2.цэргийн жинхэнэ албанд татагдсан иргэнд нарийн мэргэжлийн эмчийн үзлэг хийх;

13.2.3.цэргийн албанд тэнцсэн иргэнийг цэргийн жинхэнэ алба хаалгах шийдвэр гаргаж, цэргийн анги, байгууллагад хуваарилах;

13.2.4.иргэнээс цэрэг татлагатай холбогдуулан гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх.

13.3.Цэрэг татлагын товчоо иргэнийг энэ хуулийн 16.2-т заасныг үндэслэн цэргийн жинхэнэ албанд татахаас тухайн жил түр чөлөөлөх эрхтэй.

13.4.Цэрэг татлагатай холбогдох асуудлыг товчооны гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

13.5.Товчооны шийдвэрийн талаархи гомдол, маргааныг аймаг, нийслэлийн Засаг дарга шийдвэрлэнэ.

13.6.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга цэрэг татлага явуулахад шаардлагатай байр, тээврийн хэрэгслээр хангаж, дэмжлэг үзүүлэх албан тушаалтныг томилж ажиллуулах үүрэгтэй.

14 дүгээр зүйл.Хугацаат цэргийн албанаас түр чөлөөлөх, нөхөн хаалгах

14.1.Хугацаат цэргийн алба хаагчийг эрүүл мэндийн байдал, ар гэрийн гачигдал зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар хугацаат цэргийн албанаас түр чөлөөлж болно.

14.2.Хугацаат цэргийн алба хааж байхдаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн бол хугацаат цэргийн албанаас алба хаасан хугацаа харгалзахгүйгээр түр чөлөөлнө.

14.3.Хугацаат цэргийн албанаас түр чөлөөлөх асуудлыг нутгийн захиргааны байгууллагын тодорхойлолт, цэргийн эмнэлгийн магадалгаа, шүүхийн шийдвэрийг үндэслэн хилийн ба дотоодын цэрэг, төрлийн цэргийн командлал шийдвэрлэнэ.

14.4.Хугацаат цэргийн албанаас түр чөлөөлөгдсөн хугацаат цэргийн алба хаагч энэ зүйлийн 14.1, 14.2-т заасан шалтгаан арилмагц цэргийн албаны үлдсэн хугацааг нөхөн хаана.

15 дугаар зүйл.Хугацаат цэргийн албанаас халах

15.1.Энэ хуулийн 7.1-д заасан хугацаагаар цэргийн алба хаасан иргэнийг бэлтгэлээр халж, дайчилгааны бэлтгэл нөөцийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ.

15.2.Хугацаат цэргийн албаны хугацаа дуусахаас өмнө нийтээр халах шийдвэрийг Улсын Их Хурал гаргана.

15.3.Цэргийн албаа үлгэр жишээчээр хааж байгаа хугацаат цэргийн алба хаагчийг хилийн ба дотоодын цэрэг, төрлийн цэргийн командлалын саналыг үндэслэн цэргийн мэргэжлийн дээд удирдлагын даргын шийдвэрээр цэргийн албаны хугацаа дуусахаас гурван сарын өмнө бэлтгэлээр халж болно.

15.4.Цэргийн албанаас халагдсан хугацаат цэргийн алба хаагчийн тээвэр, хоол, хүнс, байрны зардлыг аймаг, нийслэл хүртэл хилийн ба дотоодын цэрэг, төрлийн цэргийн командлал, сум, хорооны төв хүртэл аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын Газар тус тус хариуцна.

15.5.Хугацаанаас өмнө түр чөлөөлөгдсөн болон орон нутгийн чөлөөгөөр яваа хугацаат цэргийн алба хаагчийн орон нутагтаа очих, буцах зардлыг цэргийн анги, байгууллага олгоно.

15.6.Хугацаат болон цэргийн гэрээт алба хаасан хугацааг иргэний ажилласан жилд тооцно.

16 дугаар зүйл.Тайван цагт хугацаат цэргийн албанд татахаас чөлөөлөх

16.1.Иргэнийг хугацаат цэргийн албаны цэрэг татлагаас дараахь үндэслэлээр чөлөөлнө:

16.1.1.эрүүл мэндийн байдлаар цэргийн албанд тэнцэхгүй болох нь нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр тогтоогдсон;



16.1.2.цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа болон хаасан;
16.1.3.эхнэр нь хөгжлийн бэрхшээлийн 1, 2 дугаар зэрэг тогтоолгосон.

16.2.Иргэнийг хугацаат цэргийн албаны ээлжит татлагаас дараахь үндэслэлээр тухайн жилд түр чөлөөлж болно:

16.2.1.ээлжит цэрэг татлагаар эрүүл мэндээр тэнцээгүй;

16.2.2.60-аас дээш настай эцэгтэй, 55-аас дээш настай эхтэй, хөгжлийн бэрхшээлийн 1, 2 дугаар зэрэг тогтоолгосон эцэг, эхтэй, эсхүл эцэг, эхийн аль нэг нь хөдөлмөрийн чадваргүй, тэднийг хууль ёсоор асран хамгаалах, харгалзан дэмжих өөр хүнгүй бол хамт амьдардаг эсэхийг харгалзахгүйгээр;

16.2.3.сургуулийн өмнөх насны хоёр буюу түүнээс дээш хүүхэдтэй;

16.2.4.эхнэр нь жирэмсэн бөгөөд сургуулийн өмнөх насны нэг хүүхэдтэй;

16.2.5.хууль ёсоор асран хамгаалах, харгалзан дэмжих өөр хүнгүй 16 хүртэлх насны төрсөн дүүтэй, эсхүл хөгжлийн бэрхшээлийн 1, 2 дугаар зэрэг тогтоолгосон төрсөн ах, эгч, дүүтэй;

16.2.6.хугацаат цэргийн албанд татах иргэний хяналтын тоонд багтаагүй иргэнийг;

16.2.7.гэмт хэргийн улмаас хууль сахиулах байгууллагад шалгагдаж байгаа болон ял эдэлж байгаа иргэнийг.

16.3.Энэ зүйлийн 16.2-т заасан үндэслэлийг аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын тодорхойлолт, төрсний болон үрчлэлтийн гэрчилгээ, иргэний үнэмлэх, гэрлэгсдийн баталгаа, хөгжлийн бэрхшээлтэйг тогтоосон баримт, эмнэлгийн магадалгааг үндэслэн тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ЦЭРГИЙН ГЭРЭЭТ АЛБАНД ЭЛСҮҮЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ

17 дугаар зүйл.Цэргийн гэрээт албанд элсүүлэх

17.1.Цэргийн гэрээт албанд хугацаат цэргийн алба хаасан иргэнийг цэргийн анги, байгууллагын захирагч, дарга элсүүлж, гэрээ байгуулан албан тушаалд томилно.

17.2.Цэргийн гэрээт алба хаах журмыг Засгийн газар батална.

18 дугаар зүйл.Цэргийн гэрээт алба дуусгавар болох

18.1.Цэргийн гэрээт алба дараахь тохиолдолд дуусгавар болно:

18.1.1.цэргийн жинхэнэ алба хаах гэрээний хугацаа дууссан;

18.1.2.эрүүл мэндийн байдлаар цэргийн албанд тэнцэхгүй болох нь нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр тогтоогдсон;

18.1.3.цэргийн гэрээт алба хаах насны дээд хязгаарт хүрсэн.

ТАВДУГААР БҮЛЭГ

ЦЭРГИЙН ЖИНХЭНЭ АЛБА ХААХ ЖУРАМ

19 дүгээр зүйл. Цэргийн жинхэнэ алба хаах болзол

19.1.Офицер, ахлагчийг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг баримтлан албан тушаалд томилно.

19.2.Офицер, ахлагч нь дараахь шалгуур үзүүлэлтийг хангасан байна:

19.2.1.дипломын болон түүнээс дээш боловсролтой байх;

19.2.2.мэргэжил, мэргэшил, ур чадварын түвшин нь томилогдох албан тушаалын ажлын байрны шаардлагыг хангасан байх;

19.2.3.биеийн эрүүл мэндээр цэргийн жинхэнэ албанд тэнцэх тухай цэргийн эмч нарын комиссын дүгнэлт гарсан байх;

19.2.4.бие бялдрын ерөнхий шалгуур үзүүлэлтийг хангасан байх;

19.2.5.цэргийн алба хаагчийн ёс зүйн шаардлага хангасан байх.

19.3.Ажлын зайлшгүй шаардлага, мэргэжлийн онцлогийг харгалзан офицер, ахлагчийн алба хаагчид тавигдах ерөнхий шаардлагыг хангасан 35 хүртэлх насны иргэнийг офицерын, 30 хүртэлх насны иргэнийг ахлагчийн албанд авч болох бөгөөд офицер, ахлагчийн албанд авах уг иргэнийг цэргийн бэлтгэл, сургалтад хамруулна.

19.4.Орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэнд, ар гэрийн гачигдлын улмаас цэргийн албанаас чөлөөлөгдсөн бэлтгэл офицер, ахлагчийг цэргийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш таван жилийн дотор энэ зүйлийн 19.2-т заасан шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд офицер, ахлагчийн албанд эгүүлэн авч болно.

19.5.Алба хаах насны дээд хязгаарт хүрч цэргийн тэтгэвэр тогтоолгосон дээд офицер, офицер, ахлагч, энэ зүйлийн 19.3-т заасан наснаас хэтэрсэн цэргийн мэргэжил эзэмшээгүй иргэнийг офицер, ахлагчийн орон тоонд ажиллуулахыг хориглоно.

19.6.Цэргийн анги, байгууллагын захирагч, дарга, түүнээс дээших удирдах албан тушаалд цэргийн алба хаагч ажиллах хугацаа дөрвөн жил байх бөгөөд ажлын шаардлагаар нэг жилээс илүүгүй хугацаагаар сунган ажиллуулж болно.

19.7.Офицерын удирдах албан тушаалд цэргийн мэргэжил эзэмшээгүй иргэнийг ажиллуулахыг хориглоно.

19.8.Энэ зүйлийн 19.6-д заасан хугацаа нь ижил түвшний албан тушаалд сэлгэн ажиллуулах болон дэвшүүлэн томилогдсон тохиолдолд хамаарахгүй.

20 дугаар зүйл.Офицер, ахлагчийн албан тушаалыг түр хавсран гүйцэтгэх

20.1.Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр гурваас дээш сарын хугацаагаар түр эзгүй байгаа алба хаагчийн үүргийг өөр алба хаагчаар хавсран гүйцэтгүүлж болно.



20.2.Албан үүргийг түр хавсран гүйцэтгэсэн алба хаагчид хавсран гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувиар урамшуулал олгоно.

20.3.Цэргийн алба хаагчийн түр суларсан орон тоог нөхөж ажиллуулах, албан үүргийг түр хавсран гүйцэтгэх журмыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах

21.1.Цэргийн жинхэнэ алба хаагчийг албан ажлын шаардлага, эсхүл эрүүл мэндийн байдал, өөрийн хүсэлтийг харгалзан өөр албан тушаалд шилжүүлэн томилж болно.

21.2.Ажлын шаардлагыг харгалзан офицерыг захиргааны санаачилгаар нэг албан тушаалаас нөгөө албан тушаалд сэлгэх болон шилжүүлэн томилно.

21.3.Цэргийн жинхэнэ алба хаагчийг өөр албан тушаалд сэлгэн ажиллуулахдаа эрхэлж байгаа албан тушаалын цалин хөлс, цэргийн цолыг бууруулж болохгүй.

22 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийг албан тушаалаас чөлөөлөх

22.1.Цэргийн алба хаагчийг дараахь үндэслэлээр албан тушаалаас чөлөөлнө:

22.1.1.анги, байгууллага татан буугдсан, орон тооны өөрчлөлтөөр албан тушаал нь хасагдсан;

22.1.2.өөр ажилд томилогдсон;

22.1.3.цэргийн жинхэнэ албанд биеийн эрүүл мэндээр тэнцэхгүй тухай цэргийн эмнэлгийн эмч нарын зөвлөгөөний дүгнэлт гарсан;

22.1.4.тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн;

22.1.5.алба хаах насны дээд хязгаарт хүрсэн;

22.1.6.өөрийн хүсэлтээр.

23 дугаар зүйл.Албан тушаал бууруулан томилох

23.1.Цэргийн алба хаагчийн албан тушаалыг захиргааны санаачилгаар доор дурдсан үндэслэлээр бууруулан томилж болно:

23.1.1.цэргийн нийтлэг дүрэмд заасны дагуу албан тушаал бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан;

23.1.2.албан тушаалын үүрэгтээ тэнцэхгүй тухай харьяа анги, байгууллагын захирагч, даргын дүгнэлт гарсан.

24 дүгээр зүйл.Цэргийн жинхэнэ албанаас халах

24.1.Офицер, ахлагчийг дараахь тохиолдолд нас харгалзахгүйгээр цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр халж болно:



24.1.1.цэргийн нийтлэг дүрэм, цэргийн алба хаагчийн ёс зүйн дүрмийг удаа дараа зөрчсөн;

24.1.2.гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

24.1.3.Энэ хуулийн 19.2.2-т заасан мэргэжил, мэргэшил, ур чадварын түвшинд тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон.

24.2.Офицер, ахлагч нь Монгол Улсын иргэний харьяатаас гарсан бол түүнийг цэргийн жинхэнэ албанаас хална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ЦЭРГИЙН ЦОЛ

25 дугаар зүйл.Цэргийн цол

25.1.Цэргийн албаны албан тушаал бүр цэргийн цолны зэрэглэлтэй байна.

25.2.Цэргийн цол, түүний зэрэглэл нь цэргийн алба хаагчид цэргийн дүрмээр тогтоогдсон эрх, үүрэг, мөнгөн болон материаллаг хангалтын хэмжээг тодорхойлох үндэслэл болно.

25.3.Монгол Улсын цэргийн байгууллагад дараахь цэргийн цолыг хэрэглэнэ:

25.3.1.офицер нь “дэслэгч”, “ахлах дэслэгч”, “ахмад”, “хошууч”, “дэд хурандаа”, “хурандаа”, “бригадын генерал”, “хошууч генерал”, “дэслэгч генерал”, “генерал” цолтой байх;

25.3.2.ахлагч нь “дэд ахлагч”, “ахлагч”, “ахлах ахлагч”, “сургагч ахлагч”, “тэргүүн ахлагч” цолтой байх;

25.3.3.хугацаат болон гэрээт цэргийн алба хаагч нь “байлдагч”, “ахлах байлдагч”, “дэд түрүүч”, “түрүүч”, “ахлах түрүүч” цолтой байх.

25.4.Дэслэгч, ахлах дэслэгч, ахмад цолтой офицерыг “дунд офицер”, хошууч, дэд хурандаа, хурандаа цолтой офицерыг “ахлах офицер”, бригадын генерал, хошууч генерал, дэслэгч генерал, генерал цолтой офицерыг “дээд офицер” гэнэ.

26 дугаар зүйл.Цэргийн цол олгох албан тушаалтан

26.1.Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч дээд офицерын цолыг олгоно.

26.2.Цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын дарга нь дараахь цэргийн цолыг олгоно:

26.2.1.офицерын анхны цолыг;

26.2.2.ахлах офицерын “хурандаа” цолыг;

26.2.3.цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын цэргийн алба хаагчийн цолыг.



26.3.Цэргийн байгууллагын дарга, төрлийн цэргийн командлагч нь дараахь цэргийн цолыг олгоно:

26.3.1.“хурандаа” цолноос бусад офицерын цолыг;

26.3.2.ахлагчийн анхны болон “сургагч ахлагч”, “тэргүүн ахлагч” цолыг.

26.4.Цэргийн нэгтгэл, анги, байгууллагын захирагч, дарга нь дараахь цэргийн цолыг олгоно:

26.4.1.ахлагчийн анхны болон “сургагч ахлагч”, “тэргүүн ахлагч”-аас бусад ахлагчийн цолыг;

26.4.2.хугацаат болон цэргийн гэрээт алба хаагчийн цолыг.

26.5.Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч тогтооно.

26.6.Дээд офицeroос бусад цэргийн алба хаагчийн албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

26.7.Офицер, ахлагчид цэргийн цолыг анхны цолноос эхлэн дэс дараалан олгоно.

26.8.Дайчилгааны сургууль, цугларалт, цэрэг-стратегийн сургалтад хамрагдсан цэргийн бэлтгэл үүрэгтэнд түүний эзэмшсэн цэргийн мэргэжил, томилгоот албан тушаалын цолны зэрэглэлийг харгалзан цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын дарга цэргийн цолыг олгоно.

27 дугаар зүйл.Цэргийн цолыг хэрэглэх

27.1.Цэргийн алба хаагч цэргийн жинхэнэ алба хааж байхдаа, цэргийн бэлтгэл үүрэгтэн дайчилгааны сургууль, цугларалтад оролцох үедээ цэргийн цолыг хэрэглэнэ.

27.2.Цэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн цолны өмнө “бэлтгэл”, цэргийн бэлтгэл албанд байх нас хэтэрсэн, эрүүл мэндээр цэргийн албанд тэнцэхгүй гэж эмнэлгийн дүгнэлт гарсан бэлтгэл үүрэгтний цэргийн цолны өмнө “чөлөөнд байгаа” гэсэн тодотголыг хэрэглэнэ.

27.3.Энэ хуулийн 3.1.1-д заасан цэргийн алба хаагчаас бусад албан тушаалтан хуульд өөрөөр заагаагүй бол цэргийн цол хэрэглэхийг хориглоно.

27.4.Цэргийн цолны нэр, тэмдэг, түүний загварыг цэргийн байгууллагаас бусад төрийн болон төрийн бус байгууллага, албан тушаалтан хэрэглэхийг хориглоно.

28 дугаар зүйл.Цэргийн цолыг бууруулах, хураан авах, сэргээх

28.1.Цэргийн алба хаагч сахилгын зөрчил гаргаж албан тушаал буурсан тохиолдолд түүнд тухайн ажиллах албан тушаалын цолыг эдлүүлнэ.

28.2.Гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлсэн болон Монгол Улсын харьяатаас гарсан цэргийн алба хаагчийн цэргийн цолыг цол олгосон албан тушаалтны шийдвэрээр хурааж авна.

28.3.Бэлтгэл офицер, ахлагчийг ажлын зайлшгүй шаардлагаар цэргийн жинхэнэ албанд эгүүлэн авбал түүний цэргийн цолыг сэргээнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБА

29 дүгээр зүйл.Цэргийн дүйцүүлэх алба, түүний төрөл

29.1.Цэргийн дүйцүүлэх алба нь биеэр дүйцүүлэх болон мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах гэсэн хэлбэртэй байна.

29.2.Монгол Улсын иргэн шашин шүтлэг, ёс зүйн болон хуульд заасан бусад шалтгаанаар биеэр дүйцүүлэн хааж болно.

29.3.Хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн алба хаагаагүй иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаана.

30 дугаар зүйл.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах

30.1.Монгол Улсын иргэн 18-25 насны цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн шашин шүтлэг, ёс зүйн шалтгаанаар цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж болно.

30.2.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах хугацаа 24 сар байна.

30.3.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэнийг аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэргийн штабын шийдвэрээр гамшгаас хамгаалах, хил хамгаалалтад туслах, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцуулж болно.

30.4.Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журмыг Засгийн газар батална.

30.5.Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг Засгийн газар жил бүр батална.

30.6.Цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний албанд цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр хоёроос дээш жил алба хаасан төрийн тусгай алба хаагчийг цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаасанд тооцож, цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ.

30.7.Захиргааны санаачилгаар буюу өөрийн хүсэлтээр алслагдсан сум, сум дундын болон багийн эмнэлэгт эмч, сум, багийн сургуульд багшаар гурван жил ажилласан иргэнийг цэргийн дүйцүүлэх албыг хаасанд тооцож, цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ.

30.8.Алслагдсанд тооцох сумдын жагсаалтыг Засгийн газар батална.

30.9.Энэ зүйлийн 30.6, 30.7-д заасан иргэний дүйцүүлэх алба хаасан хугацааг анх шийдвэр гарсан өдрөөс эхлэн тооцож хугацаа дуусмагц цэргийн бүртгэлд авна.



31 дүгээр зүйл. Дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах

31.1. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах мөнгөн төлбөрийн хэмжээг хугацаат цэргийн алба хаагчийн тухайн жилийн хувьсах зардлаар тооцож Засгийн газар жил бүр батална.

31.2. Иргэн цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр оруулан хаах, төлбөрөөс чөлөөлөх шийдвэрийг цэргийн штабын саналыг үндэслэн аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Засаг дарга гаргана.

31.3. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан иргэнийг цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэнэ.

31.4. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг хангасан, дараахь шалтгаанаар цэргийн жинхэнэ албаны татлагад ороогүй иргэнээр уг төлбөрийг нөхөн төлүүлнэ:

31.4.1. гадаадад хувиараа ажил, хөдөлмөр эрхэлж байсан, эсхүл цагаачлан амьдарч байгаад эх орондоо эргэж ирсэн;

31.4.2. иргэний шилжин суурьших хөдөлгөөний бүртгэл завсардсан.

31.5. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаахаас дараахь үндэслэлээр чөлөөлнө:

31.5.1. энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан үндэслэлээр цэргийн жинхэнэ албанаас жил дараалан чөлөөлөгдөж хугацаат цэргийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн эрэгтэй;

31.5.2. эрүүл мэндээр тэнцэхгүйн улмаас тайван цагт цэргийн жинхэнэ алба хаахаас чөлөөлөгдсөн иргэн;

31.5.3. цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаасан иргэн.

31.6. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээ нь хуулийн дагуу цэргийн албанаас чөлөөлөгдсөн жилд харгалзуулан долоон жилд 14 хувь, зургаан жилд 28 хувь, таван жилд 32 хувь, дөрвөн жилд 46 хувь, гурван жилд 60 хувь, хоёр жилд 74 хувь, нэг жилд 88 хувь, чөлөөлөгдөж байгаагүй бол 100 хувь байна.

31.7. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журмыг Засгийн газар батална.

31.8. Цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаасан мөнгөн төлбөрийн 50 хувийг улсын, үлдэх 50 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, батлан хамгаалах үйл ажиллагаанд зарцуулна.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ АЛБА ТҮҮНИЙ СУРГАЛТ

32 дугаар зүйл.Цэргийн бэлтгэл алба

32.1.Цэргийн бэлтгэл албанд байгаа нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнийг цэргийн анги, салбарт цэргийн мэргэжлийн дагуу зохих албан тушаалд бүртгүүлэх, цэргийн мэргэжил олгох, давтан бэлтгэх сургалтад хамруулах, цэргийн дайчилгаатай сургуульд оролцуулах үүргийг аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэргийн штаб хүлээнэ.

32.2.Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн цэргийн бэлтгэл албанд байх хугацаандаа цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдах, орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд оролцох томилгоот үүргээ гүйцэтгэх бэлтгэлтэй байх үүрэг хүлээнэ.

32.3.Цэргийн бэлтгэл албанд дээд офицер 65 нас, ахлах офицер 60 нас, дунд офицер, ахлагч 55 нас, эмэгтэй офицер, ахлагч болон байлдагч, түрүүч 50 нас хүртэл бүртгэлтэй байна.

32.4.Цэргийн сургуулийг иргэний мэргэжлээр төгссөн боловч цэргийн мэргэжлээр дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн иргэнийг бэлтгэл офицeroор бүртгэнэ.

32.5.Цэргийн бэлтгэл албанд байх нас хэтэрсэн, эрүүл мэндээр цэргийн албанд тэнцэхгүй болсон тухай эмнэлгийн дүгнэлт гарсан бэлтгэл үүрэгтнийг чөлөөнд гаргаж, бүртгэлээс хасна.

33 дугаар зүйл.Цэргийн бэлтгэл албаны сургалт

33.1.Цэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн болон цэрэг-техникийн бэлтгэлийг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжийн дагуу цэргийн мэргэжил олгох болон давтан бэлтгэх сургалт, дайчилгааны сургууль, цугларалтад татан оролцуулна.

33.2.Бэлтгэл офицерын болон цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний давтан бэлтгэх сургалтыг Дайчилгааны тухай хуулийн² дагуу цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагын төлөвлөгөөгөөр төрлийн цэргийн командлал зохион байгуулна.

33.3.Цэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг зохион байгуулахдаа цэргийн чухал мэргэжлийн бэлтгэл офицeroуд, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг таван жилд нэг удаа тус бүр нэг сараас доошгүй хугацаагаар явуулна.

33.4.Цэргийн нэгтгэл, ангийн байлдааны орон тоонд оногдуулан бүртгэгдсэн цэргийн бэлтгэл үүрэгтнийг энэ зүйлийн 33.3-т заасан сургалтад хамрагдсан эсэхийг харгалзахгүйгээр цэргийн дайчилгаатай хээрийн сургуульд татан оролцуулна.

² Дайчилгааны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1998 оны 06 дугаарт нийтлэгдсэн.



33.5.Цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн, бэлтгэл офицерын цэргийн мэргэжил олгох, давтан бэлтгэх сургалт болон цэргийн дайчилгааны сургуулиас чөлөөлөх асуудлыг цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага шийдвэрлэнэ.

33.6.Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнийг цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтад заавал хамруулна.

33.7.Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтад хамрагдах нийт хугацаа гурван сар байна.

33.8.Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэнд цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтыг аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна.

33.9.Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний сургалтад төрлийн цэргийн командлал дэмжлэг үзүүлнэ.

33.10.Төрийн захиргааны бүх шатны байгууллагын удирдах албан тушаалтны цэргийн бэлтгэл сургалтыг Засгийн газрын шийдвэрээр батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

33.11.Цэргийн бэлтгэл үүрэгтнийг цэргийн сургалт, цэргийн дайчилгаатай сургуульд оролцох хугацаанд түүний эрхэлж байсан ажил, албан тушаалыг үндсэн байгууллага нь хэвээр хадгална.

33.12.Цэргийн бэлтгэл үүрэгтнийг цэргийн сургалт, цэргийн дайчилгаатай сургуульд оролцох хугацааны цалин хөлсний дундаж хэмжээг Засгийн газрын тогтоосноор батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

33.13.Цэргийн бэлтгэл үүрэгтнийг цэргийн сургалт, цэргийн дайчилгаатай сургуульд оролцох хугацаанд ажиллаж байсан байгууллага нь татан буугдсан тохиолдолд тус байгууллагыг харьяалах дээд байгууллага, эсхүл тухайн байгууллагын үүргийг шилжүүлэн авсан байгууллага зохих ажлын байраар хангана.

33.14.Цэргийн бэлтгэл үүрэгтэн хууль тогтоомжийн дагуу цэргийн мэргэжил олгох, давтан бэлтгэх сургалт, дайчилгааны сургууль, цугларалтын үед өвчилж, түүнийг дуустал эдгэрээгүй бол цугларалт дууссан өдрөөс эхлэн ажиллаж байсан байгууллага эрхэлсэн ажил, албан тушаалыг хэвээр хадгалж, холбогдох хууль тогтоомжийн дагуу тэтгэмж олгоно.

33.15.Дайчилгааны бэлтгэл нөөцийн бэлтгэл үүрэгтэн цэргийн анхан шатны болон дайчилгааны сургууль, цугларалтад оролцох үеийн цэргийн хангалтыг Дайчилгааны тухай хуулиар зохицуулна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ЦЭРГИЙН БҮРТГЭЛ

34 дүгээр зүйл.Цэргийн бүртгэл

34.1.Цэргийн бүртгэлийг аймаг, нийслэл /дүүрэг/-ийн Засаг даргын Тамгын газар зохион байгуулна.

34.2.Цэргийн бэлтгэл үүрэгтэн нь цэргийн үүрэгтний үнэмлэхтэй байна.

34.3.Цэргийн бэлтгэл алба хаах насны иргэн жил бүр цэргийн бүртгэлд бүртгүүлж, цэргийн үүрэгтний үнэмлэхэд тэмдэглэл хийлгэнэ.

34.4.Цэрэгт бүртгэлтэй мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүд цэргийн бүртгэлд бүртгүүлнэ.

34.5.Цэргийн бүртгэлд дараахь иргэн хамрагдахгүй:

34.5.1.энэ хуулийн 16.1-д заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн;

34.5.2.цэргийн жинхэнэ алба хааж байгаа;

34.5.3.ял эдэлж байгаа.

34.6.Цэргийн бүртгэлд хамрагдах иргэн дараахь үүргийг хүлээнэ:

34.6.1.нутгийн захиргааны анхан шатны нэгж /баг, хороо/-ийн байранд тогтоосон хугацаанд ирж цэргийн бүртгэлд хамрагдах;

34.6.2.цэргийн үүрэгтний үнэмлэхийг хаяж, үрэгдүүлэхгүй байх, хаяж үрэгдүүлсэн тохиолдолд нөхөж авах;

34.6.3.цэрэг татлагын үеэр гурван сараас дээш хугацаагаар гадаад улсад зорчих бол энэ тухайгаа мэдэгдэх;

34.6.4.өөр газар шилжин суурьших тохиолдолд тухайн оршин суугаа газрынхаа цэргийн бүртгэлээс хасуулж, шилжин очсон газраа цэргийн бүртгэлд бүртгүүлэх.

34.7.Цэргийн бүртгэл явуулах журмыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

АРАВДУГААР БҮЛЭГ.

ОФИЦЕР, АХЛАГЧИЙН ХУВИЙН ХЭРЭГ, ТОО БҮРТГЭЛ, ХУВИЙН БАРИМТ БИЧИГ

35 дугаар зүйл.Хувийн хэрэг, тоо бүртгэл, хувийн баримт бичиг

35.1.Цэргийн жинхэнэ албаны офицер, ахлагчийн хувийн хэргийг цэргийн бүх шатны байгууллагын хүний нөөцийн асуудал эрхэлсэн нэгж, албан тушаалтан эрхлэн нээж, жил бүр баяжилт хийж хадгална.

35.2.Офицер, ахлагчийн хувийн хэрэг нь түүний цэргийн алба хаасан тухай болон үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшний үнэлгээ, ажил байдлын тодорхойлолт, холбогдох судалгааг багтаасан байна.



35.3.Офицер, ахлагчийн хувийн хэрэг нээгдмэгц офицер, ахлагчийн үнэмлэх олгох бөгөөд үнэмлэх нь цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг батлах үндсэн баримт бичиг болно.

35.4.Цэргийн албанаас халагдаж байгаа офицер, ахлагчийн үнэмлэхэд халагдсан тухай тэмдэглэл хийж хувийн хэрэгт нь хадгална.

35.5.Цэргийн жинхэнэ албанд эргэж орсон офицер, ахлагчид үнэмлэхийг дахин олгоно.

35.6.Бэлтгэлээр халагдсан офицер, ахлагчид бэлтгэл офицер, ахлагчийн үнэмлэх олгоно.

**АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.
АЛБАН ТУШААЛТАН, ИРГЭНД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

36 дугаар зүйл.Албан тушаалтан, иргэнд хүлээлгэх хариуцлага

36.1.Ажил олгогч байгууллага, цэрэг татлагын товчооны дарга, гишүүд энэ хуулиар тогтоосон үүргийг биелүүлээгүй, түүнчлэн цэргийн үүргээ биелүүлэхэд нь иргэнд саад учруулсан албан тушаалтныг нэг зуун хорин таваас хоёр зуун тавин нэгж, иргэнийг хорин таваас нэг зуун хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

36.2.Цэргийн бүртгэлийн журам зөрчсөн, зарлан дуудах мэдэгдэл авсан боловч тогтоосон хугацаанд заасан газарт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, дайчилгааны сургууль, цугларалт болон цэрэг татлагаас зайлсхийсэн цэргийн үүрэгтэн, цэргийн насны иргэнийг аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын батлан хамгаалах асуудал эрхэлсэн нэгжийн дарга хорин таваас нэг зуун хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

36.3.Албан тушаалтан, иргэн энэ хуулийн заалтыг зөрчсөн нь гэмт хэргийн шинжтэй бол түүнд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН
ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.1992 оны 05 дугаар сарын 04-ний өдөр баталсан Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.



2 дугаар зүйл.Энэ хуулийг Цэргийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

**ДАЙНЫ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Дайны байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.16 дахь заалтын “цэргийн тоо бүртгэл” гэснийг “цэргийн бүртгэл” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Цэргийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН
ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуулийн гарчигны “Цэргийн албан хаагчийн” гэснийг “Цэргийн алба хаагчийн” гэж, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль” гэснийг “Цэргийн албаны тухай хууль” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Цэргийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



“6.1.2.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтныг албан тушаалд томилох, чөлөөлөх, халах, тэдгээрт цэргийн цол олгохдоо Цэргийн албаны тухай хуулийн холбогдох зохицуулалтыг баримтална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Цэргийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ УЛСЫН ТООЛЛОГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хүн ам, орон сууцны улсын тооллогын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтын “гэрээт цэргийн албан хаагчдын” гэснийг “цэргийн гэрээт алба хаагчийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Цэргийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Эрүүгийн хуулийн 279 дүгээр зүйлийн 279.1 дэх хэсгийн “гэрээт албан хаагч”, 280 дугаар зүйлийн 280.1 дэх хэсэг, 281 дүгээр зүйлийн 281.1, 281.2 дахь хэсэг, 289 дүгээр зүйлийн 289.2 дахь хэсгийн “гэрээт цэргийн албан хаагч” гэснийг “цэргийн гэрээт алба хаагч” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Цэргийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “гэрээт цэргийн жинхэнэ албан хаагч” гэснийг “цэргийн гэрээт алба хаагч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Цэргийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал, үүргээ гүйцэтгэх нөхцөл баталгаа, эрхийн хязгаарлалтыг тогтооход оршино.

2 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж

2.1.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Цэргийн алба хаагчийн цэргийн албаны үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн баталсан цэргийн нийтлэг дүрмээр зохицуулна.

2.4.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдох харилцааг хуулиар зохицуулна.

3 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын зарчим

3.1.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдал нь дараахь зарчимд тулгуурлана:

¹ Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 01 дүгээрт нийтлэгдсэн.



3.1.1.бүх төрлийн хангамж нь албан үүргээ гүйцэтгэхэд нийцсэн байх;

3.1.2.албаны үүргээ гүйцэтгэх үеийн халдашгүй байдал хамгаалагдсан байх;

3.1.3.захирах, захирагдах;

3.1.4.улс төрийн үйл ажиллагаанаас ангид байх.

4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

4.1.Энэ хууль нь албан үүргээ гүйцэтгэж байгаа цэргийн жинхэнэ алба хаагч, цэргийн дайчилгаатай сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн бэлтгэл үүрэгтэнд хамаарна.

4.2.Цэргийн алба хаагч ангийн байрлал, эсхүл ангийн байрлалын гадна албан үүрэг, байлдааны жижүүрлэлт, харуул, хоногийн манааны үүрэг гүйцэтгэх, ажилдаа ирэх, буцахыг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно.

4.3.Энэ зүйлийн 4.2-т зааснаас гадна доор дурдсан нөхцөлийг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно:

4.3.1.гадаад улс болон орон нутагт албан томиллолтоор ажиллах;

4.3.2.дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцах;

4.3.3.цэргийн сургалт бэлтгэл, дайчилгаатай сургууль, цугларалтад оролцох;

4.3.4.улсын хил, онц чухал объектыг хамгаалах;

4.3.5.орон нутгийн хамгаалалтын арга хэмжээнд оролцох;

4.3.6.хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчныг гамшгийн аюулаас аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хорио цээрийн дэглэмийг сахиулах;

4.3.7.тэсэрч дэлбэрэх зүйл, цацраг идэвхт болон химийн хорт бодисыг аюулгүй болгох, устгах;

4.3.8.аливаа хөнөөх хэрэгслийн хөнөөлөөс хүн ам, мал, амьтан, эд хөрөнгийг аврах, хор уршгийг арилгах;

4.3.9.энхийг дэмжих ажиллагаанд оролцох;

4.3.10.террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох;

4.3.11.томилгоот бусад үүрэг гүйцэтгэх.

4.4.Цэргийн албанд татагдагч цэрэг татлагын байрнаас цэргийн анги, байгууллагад хүрэх, хугацаат цэргийн албанаас бэлтгэлээр халагдсан иргэн цэргийн анги, байгууллагаас орон нутагт хүрэх хугацааг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн эрх

5.1.Цэргийн алба хаагч дараахь нийтлэг эрхтэй:

5.1.1.байлдааны бэлэн байдал, хууль бус үйлдэл, хууль ёсны эрх ашиг зөрчигдсэн асуудлаар санал, хүсэлт, гомдлоо бүх шатны захирагч, дарга нарт амаар болон бичгээр тавьж, шийдвэрлүүлэх;

5.1.2.цэргийн алба хааж байгаагийн төлөө албан тушаалын ангиллын, алба хаасан хугацааны, цэргийн цолны мөнгөн хангамж эдлэх;

5.1.3.албаны үүргээ гүйцэтгэх үедээ цэргийн дүрэмт хувцас, техник, материал хэрэгсэл, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдах;

5.1.4.эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрснөөр цэргийн мэргэжлийн боловсрол олгох дипломын, бакалаврын, магистрын, докторын болон давтан, мэргэжил дээшлүүлэх сургалтад төрийн зардлаар суралцах;

5.1.5.мэргэжил, мэргэшил, ур чадвар, ёс зүйн болон дадлага туршлагаараа албан тушаал дэвшин томилогдох;

5.1.6.эрүүл мэндээ хамгаалуулах;

5.1.7.цэргийн алба хаах үүргээ гүйцэтгэх явцад өөрийн эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирсан хохирлоо хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлэх.

6 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн үүрэг

6.1.Цэргийн алба хаагч дараахь нийтлэг үүрэгтэй:

6.1.1.эх орон, төр, ард түмнээ хүндэтгэн дээдлэх;

6.1.2.өргөсөн тангарагтаа үнэнч байх;

6.1.3.Монгол Улсын хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмийг чанд сахин биелүүлэх;

6.1.4.албан тушаалын үүргээ биелүүлэх;

6.1.5.захирах, захирагдах зарчмыг мөрдөх;

6.1.6.гадаад улсад үүрэг гүйцэтгэхдээ тухайн улсын болон олон улсын холбогдох хууль тогтоомжийг мөрдөх;

6.1.7.цэргийн алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих;

6.1.8.хариуцсан зэвсэг, цэргийн техникийг чадамгай эзэмшиж, хамгаалах;

6.1.9.төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцыг алба хаах хугацаандаа болон албанаас чөлөөлөгдсөний дараа задруулахгүй байх;

6.1.10.мэдлэг, мэргэшлийн түвшнээ ахиулж байх.

6.2.Захирагч, даргын гаргасан тушаал, шийдвэрийг цэргийн алба хаагч үг дуугүй биелүүлэх үүрэгтэй.

6.3.Захирагч, даргын тушаал, шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ДАВУУ ЭРХ, ЭРХИЙН ХЯЗГААРЛАЛТ

7 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн давуу эрх

7.1.Цэргийн алба хаагч дараахь давуу эрхийг эдэлнэ:



7.1.1.офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч жил бүр ажлын 18 өдөр, цэргийн сургуулийн сонсогч ажлын 25 өдрийн амралтыг биеэр эдлэх бөгөөд амрах газарт очих, буцахад зайлшгүй шаардагдах өдрийг амралтын хугацаанд тооцохгүй байх;

7.1.2.офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчид цэргийн жинхэнэ алба хаасан таван жил тутамд ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт олгох;

7.1.3.тайван цагт энхийг дэмжих ажиллагаанд оролцсон цэргийн алба хаагч, нисэх цагийн нормоо биелүүлсэн байлдааны сөнөөгч онгоц, байлдааны нисдэг тэрэгний нисэх бүрэлдэхүүн, хилийн отряд, застав болон тэдгээртэй адил нөхцөлд байрлаж байгаа цэргийн анги, байгууллага, салбарын офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийн алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцох;

7.1.4.офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч нь анги, байгууллагынхаа захирагч, даргын зөвшөөрснөөр уран бүтээл туурвих болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх;

7.1.5.цэргийн алба хаасан хугацааг иргэний ажилласан, цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтоох хугацаанд оруулан тооцох;

7.1.6.алслагдсан болон хөдөө орон нутаг алба хааж байгаа офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийг цэргийн анги, байгууллага нь орон сууцаар хангах бөгөөд цэргийн анги, байгууллагын мэдлийн орон сууцанд амьдарч байгаа офицер, ахлагчийн орон сууцны хөлсийг 30 хүртэл хувиар хөнгөлөх;

7.1.7.цэргийн анги, байгууллага офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагчийг орон сууцаар хангаагүй бол орон сууц, гэр, байшин хөлслөх тухайн орон нутгийн түрээсийн төлбөрийг 12 хавтгай дөрвөлжин метрээр тооцож цэргийн анги, байгууллага олгох;

7.1.8.офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч байнга оршин суух газартаа амины орон сууцтай болоход нь Засгийн газраас тогтоосон журмын дагуу хөнгөлөлт үзүүлэх;

7.1.9.офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч нь ажлын нөхцөл, албан тушаал, мэргэжил, мэргэжлийн зэрэг, цэргийн цол, алба хаасан хугацаа зэргийг үндэслэж тогтоосон дүрэмт хувцасны болон мөнгөн хангамжтай байхаас гадна байлдааны жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэх, харуул, манаанд гарах, хээрийн сургууль, дадлага хийх үедээ хүнсний болон эдийн хангамж, түүнчлэн нийслэлээс бусад сум, суурин газарт байрлаж байгаа цэргийн анги, салбарын офицер, ахлагч, цэргийн гэрээт алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байгаа эсэхийг үл харгалзан хүнсээр хангагдах;

7.1.10.гадаадын цэргийн сургуульд суралцагч офицер, ахлагчийн суралцах хугацааны цалин хөлс, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцах;

7.1.11.офицер, ахлагч нь цэргийн алба хаах хугацаанд болон тэтгэвэрт гарсан үедээ хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, журмын дагуу эмнэлгийн үйлчилгээнд хамрагдах;

7.1.12.хугацаат албаны байлдагч, түрүүч, цэргийн сургуулийн сонсогч, сурагчийн эмнэлгийн үйлчилгээний төлбөрийг төр хариуцах;



7.1.13.цэргийн алба хаагчийн гэр бүлийн гишүүн цэргийн эмнэлгээр үйлчлүүлэх;

7.1.14.офицер, ахлагч шилжин томилогдох, цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр халагдах үед түүнийг гэр бүлийн гишүүд, ачаа тээшний хамт оршин суух газарт нь хүргэх тээврийн хэрэгслийг анги, байгууллагаас гаргах буюу зардлыг автомашин, төмөр замын үнэлгээт хөлсөөр тооцож олгох;

7.1.15.офицер, ахлагч өөр анги, байгууллагад шилжин алба хаах болсонтой холбогдож эхнэр /нөхөр/ нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрсэн бол тэдэнд нэг сараас доошгүй хугацааны дундаж цалинтай тэнцэх тэтгэмжийг шилжүүлэн ажиллуулах шийдвэр гаргасан байгууллага олгох;

7.1.16.алслагдсан цэргийн анги, салбарт ажиллаж байгаа офицер, ахлагчийн сургуулийн насны хүүхдийн боловсролыг дэмжих зорилгоор түүний гэр бүлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэхүйц мөнгөн тусламжийг улиралд нэг удаа олгох;

7.1.17.улсын хил болон алслагдсанд тооцох анги, байгууллагад таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн застав болон түүнтэй адилтгах салбарт 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн отряд, цэргийн анги, салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгох;

7.1.18.цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байх үедээ гэмтсэн, эрүүл мэнд нь хохирсон бол эмчилгээний зардал, хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэсэн зардлыг төр хариуцах;

7.1.19.цэргийн алба хаагч ээлжийн амралтаар өөрийн төрсөн нутагтаа очих, буцаж ирэх замын зардлыг хоёр жилд нэг удаа цэргийн анги, байгууллага олгох;

7.1.20.хугацаат цэргийн алба хаагчийн шуудангийн үйлчилгээний зардлыг цэргийн анги, байгууллага хариуцах;

7.1.21.цэргийн тэтгэвэр тогтоолгосон бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицерт урьд эрхэлж байсан албан тушаалын цэргийн цолны цалинг харьяалсан үндсэн байгууллага сар бүр олгох.

7.2.Цэргийн алба хаагчийн хангалт, үйлчилгээний төрөл, тэдгээрийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

7.3.Офицер, ахлагч, гэрээт цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын хуулиар² зохицуулна.

7.4.Алслагдсанд тооцох анги, салбарын жагсаалтыг Засгийн газар тогтоох бөгөөд тусламжид шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгана.

7.5.Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй цэргийн алба хаагчид албан тушаалын 1,5 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно.

² Эрүүл мэндийн даатгалын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 08 дугаарт



7.6.Офицер, ахлагчийн гэр бүлийн гишүүд анги, байгууллагад түүнтэй хамт ажиллаж болно.

7.7.Цэргийн тэтгэвэр тогтоолгосон дээд офицер, офицер, ахлагчийг эзэмшсэн мэргэжлийнх нь чиглэлээр төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэлтэйд тооцож, төрийн байгууллагад энгийн албан тушаалд томилон ажиллуулж болно.

8 дугаар зүйл.Цэргийн алба хаагчийн эрхийн хязгаарлалт

8.1.Цэргийн алба хаагч дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

8.1.1.улс төрийн нам, эвсэл, холбооны гишүүн байх, улс төрийн үйл ажиллагаанд оролцох;

8.1.2.цэргийн нэгтгэл, анги, байгууллагад улс төрийн үйл ажиллагаа зохион байгуулах;

8.1.3.төрийн бодлого, хууль тогтоомж, захирагч, даргын тушаалыг эсэргүүцэх, биелүүлэхээс татгалзах;

8.1.4.захирагч, даргын зөвшөөрөлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох;

8.1.5.хугацаат цэргийн алба хаагч цэргийн анги, байгууллагын зохион байгуулснаас бусад сургууль, дамжаанд суралцах;

8.1.6.захирагч, даргын зөвшөөрөлгүйгээр гадаад улсад зорчих;

8.1.7.хуулийн дагуу нууцын зэрэгт хамаарах баримт бичиг, зэвсэг, техник хэрэгсэлтэй ажиллаж байсан цэргийн алба хаагч цэргийн албанаас бэлтгэлээр халагдсаны дараа гурван жилийн дотор гадаад улсад байнга оршин суухаар явах;

8.1.8.цэргийн анги, байгууллагад шашин сурталчлах;

8.1.9.албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон цэргийн дүрэмт хувцас өмсөн үедээ согтууруулах ундаа хэрэглэх;

8.1.10.мансууруулах болон сэтгэцэд нөлөөтэй бодис хэрэглэх.

8.2.Цэргийн албаны үүргийн онцлог, түүнд тавигдах шаардлагыг үндэслэн цэргийн алба хаагчийн эрхийг дараахь байдлаар хязгаарлаж болно:

8.2.1.цэргийн алба хаагчийг хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад хэм хэмжээнд зааснаас илүү цагаар ажиллуулах;

8.2.2.захирагч, даргын шийдвэрээр цэргийн алба хаагчийн амралтын цагийг цэргийн дүрэмд заасны дагуу хязгаарлах;

8.2.3.цэргийн алба хаагчийн алба хааж байгаа ангийн байршлаас шалтгаалан түүний оршин суух газрыг тухайн анги, байгууллагын захирагч, дарга тогтоох.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЦАЛИН ХӨЛС, ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

9 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн цалин хөлс

9.1.Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө цэргийн алба хаагчид цалин хөлс олгоно.

9.2.Цэргийн алба хаагчийн цалин хөлс нь үндсэн ба цэргийн цолны цалингаас гадна доор дурдсан нэмэгдлээс бүрдэнэ:

- 9.2.1.байлдааны жижүүрлэлтийн болон тусгай үүргийн;
- 9.2.2.удаан жил ажилласны;
- 9.2.3.онцгой нөхцөлийн;
- 9.2.4.цэргийн мэргэжлийн зэргийн;
- 9.2.5.хилийн;
- 9.2.6.төрийн нууцад хамаарах мэдээ мэдээлэл хариуцсаны;
- 9.2.7.боловсролын болон эрдмийн зэрэг, цолны.

9.3.Цэргийн алба хаагчийн цалин, бусад хангамжаас хууль тогтоомжид зааснаас бусад суутгал хийхийг хориглоно.

9.4.Цэргийн алба хаагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.

9.5.Дотоод, гадаадын цэргийн сургуульд суралцаж байгаа сонсогч, сурагчийн цалин хөлсний хэмжээ, нэмэгдэл олгох журмыг батлан хамгаалах, хил хамгаалалтын болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

9.6.Цэргийн алба хаагчид хууль тогтоомжид заасан бусад нэмэгдэл, урамшууллыг олгож болно.

ТАВДУГААР БҮЛЭГ ГАЛТ ЗЭВСЭГ ХЭРЭГЛЭХ

10 дугаар зүйл.Цэргийн алба хаагч галт зэвсэг хэрэглэх

10.1.Цэргийн хүрээ, хотхон, ангийн захирагч, даргын тушаалаар томилогдсон жижүүр, харуул, манааны бүрэлдэхүүн, тусгай үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн алба хаагч, цэргийн тусгай ачаа хамгаалагч нь аливаа халдлага, гэмт этгээдийн үйлдэл, эсэргүүцлийг өөр арга, хэрэгслээр таслан зогсоох боломжгүй дараахь тохиолдолд эцсийн арга хэмжээ болгон галт зэвсэг хэрэглэх эрхтэй.

10.1.1.цэргийн харуул хамгаалалтад байгаа объектод хүч хэрэглэн халдах;

10.1.2.байлдааны зэвсэг, техникийг булаан авах оролдлого хийх;

10.1.3.цэргийн алба хаагч болон иргэний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болохуйц халдлага хийх;

10.1.4.оргон зугтсан онц аюултай гэмт хэрэгтнийг баривчлахад дэмжлэг үзүүлэх.

10.2.Боломжтой бүх тохиолдолд зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан анхааруулна.

10.3.Цэргийн алба хаагч аюулын дохио өгөх, тусламж дуудах, араатан амьтнаас өөрийгөө болон бусдыг хамгаалахын тулд зэвсэг хэрэглэж болно.

10.4.Цэргийн алба хаагчийн зэвсэг авч явах, хэрэглэхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг цэргийн дүрмээр зохицуулна.

10.5.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох үеийн галт зэвсэг хэрэглэх нөхцөл, тохиолдлыг тухайн энхийг дэмжих ажиллагааны дүрмээр зохицуулна.



**ЗУРГАДУГААР БҮЛЭГ
БУСАД ЗҮЙЛ**

11 дүгээр зүйл. Хүлээлгэх хариуцлага

11.1. Монгол Улсын хууль тогтоомж, өргөсөн тангаргаа зөрчсөн цэргийн алба хаагчид хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР,
ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн гарчиг, 1 дүгээр зүйл, 6 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 7 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11 дүгээр зүйл, 12 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 17¹ дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 17² дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 6 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн гарчиг, 21 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын

тухай хуулийн гарчиг, 1 дүгээр зүйлийн “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хуулийн гарчиг, 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 2 дугаар зүйлийн гарчиг, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1, 3.2 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт, 2 дугаар бүлгийн гарчиг, 5 дугаар зүйлийн гарчиг, 5.1, 5.2, 5.3, 5.4 дэх хэсэг, 6 дугаар зүйлийн гарчиг, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 6.1.1 дэх заалт, 7 дугаар зүйлийн гарчиг, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.4, 10.5, 10.6, 10.7 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсгийн “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж, 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль” гэснийг “Цэргийн албаны тухай хууль” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийн “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

АХМАД НАСТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “гавьяат цолтон” гэсний дараа “генерал цолтой цэргийн бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицер” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.9, 5.1.11 дэх заалтын “ахмад дайчин” гэсний дараа “генерал цолтой цэргийн бэлтгэл, чөлөөнд байгаа дээд офицер” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 414 дүгээр зүйлийн 414.1 дэх хэсгийн “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 172 дугаар зүйлийн 172.4.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“172.4.6.энхийг дэмжих ажиллагаанд оролцох явцад үйлдсэн гэмт хэрэгт тухайн цэргийн багийн захирагч, эрх бүхий албан тушаалтан,”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, 74 дүгээр зүйлийн 74.6 дахь хэсэг, 274 дүгээр зүйлийн 274.2 дахь хэсэг, 278 дугаар зүйлийн гарчиг, 278 дугаар зүйлийн 278.1, 278.2 дахь хэсэг, 280 дугаар зүйлийн 280.1 дэх хэсэг, 281 дүгээр зүйлийн 281.1, 281.2 дахь хэсэг, 287 дугаар зүйлийн 287.1 дэх хэсэг, 289 дүгээр зүйлийн 289.1 дэх хэсэг, 291 дүгээр зүйлийн 291.1 дэх хэсэг, 292 дугаар зүйлийн 292.1 дэх хэсгийн “цэргийн албан” гэснийг “цэргийн алба” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Дугаар 35

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зэвсэгт хүчний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Галт зэвсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын төслийг батлах саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны 09 дүгээр
сарын 01-ний өдөр

Дугаар 36

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их



Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Цэргийн албаны тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг батлах саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 4.0

Индекс: 14003